



**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН “ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ”-Н 2025 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-012199/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2095025/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

/...../

Биелэлтийг тайлагнасан:

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн
Үйлдвэр Техникийн Газрын захирал

/Д. Баярсайхан/

Байгаль орчны инженер

/Д. Чулуунчимэг/

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	4
3. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 8	
4. ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН.....	9
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
6. НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	17
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	19
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	19
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	19
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	22
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	24
13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	34
14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	37
15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ	39
16. ДҮГНЭЛТ	39
17. ХАВСРАЛТУУД	40

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга:

“Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал төсөл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. “Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөх цав цемент-шохойн үйлдвэрийн төсөл болон дагалдах уурхайнуудын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэхээр 2014 онд “МАК ЦЕМЕНТ” ХХК байгуулагдсан бөгөөд Хөөтийн уурхайн үйл ажиллагааг хариуцдаг билээ.

Компанийн байгаль орчны бодлого:

Бидний эрхэм зорилго: Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсч болох аливаа сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах, байгалийн нөөцийг удаан хугацаанд тогтвортой ашиглах нь компанийн нэн тэргүүний зорилго юм.

Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улс болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны холбогдолтой хууль, журам, гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл болох учиртай.

Баримтлах бодлого: Манай компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг.

баталсан Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;

- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

- Үл нөхөн сэргээгдэх байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;

- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ

тууштай нэвтрүүлэх;

- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;

- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг болно.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ордын ерөнхий мэдээлэл, байршил:

Хөөтийн нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт Говь Угтаал-Баянжаргалангийн өндөрлөгийн төв хэсэгт тогтсон Хөөтийн хотгорт оршино. Ордын тусгай зөвшөөрлийн MV-12199, MV-020297 талбайнуудын газарзүйн солбилцол:

Хүснэгт 1: Ордын газарзүйн солбилцлүүд

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	107° 40' 00"	45° 41' 30"	3	107° 44' 00"	45° 40' 00"
2	107° 44' 00"	45° 41' 30"	4	107° 40' 00"	45° 40' 00"

Хөөтийн нүүрсний орд ба хот суурин газрууд, бусад объектуудын байршил:

Хүснэгт 2: Бусад байршил хоорондын зай

	Хот, суурин газрын нэр	Ордын байршил	
		Зүг	Зай [км]
1	Улаанбаатар хот	Зүүн урагш	300
2	Чойр	Баруун урагш	100
3	Мандалговь	Зүүн хойш	130
4	Баянжаргалан сум Арагтай	Баруун тийш	26

Зураг 1: Хөөтийн нүүрсний ордын байр зүйн зураг

Дэд бүтэц: Хөөтийн нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 300 км, төмөр замын зангилаа бүхий Чойр хотоос баруун урагш 100 км, аймгийн төв Мандалговь сумаас зүүн хойш 130 км, Баянжаргалан сумын төв Арагтайгаас баруун тийш 26 км зайд Хөөтийн хотгорт оршино.

Зам тээврийн нөхцөл: Орд нь бүтэн жилийн турш бусад хот сууринтай зам тээврээр холбогдох боломжтой бөгөөд Улаанбаатар хотоос төмөр замын Чойр өртөө болон Говь-Сүмбэр аймгийн төв хүртэл асфальтан замаар, цааш Говь-Сүмбэр аймгийн төвөөс орд хүртэл шороон замаар холбогдоно.

Уурхайн жилийн хүчин чадал: Техник эдийн засгийн үндэслэлийн дагуу ашиглалтыг явуулж 2025 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 1195-1165 метрийн түвшин хүртэл гүнзгийрч нийт 1,5 сая.м³ хөрс хуулж, 332 мян.тн нүүрс олборлох зорилттой ажиллаж байна.

Уурхайн ажиллах горим: 2025 онд Хөөтийн уурхайн ажиллах горим дараах байдлаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 3: Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ	Тайлбар
1	Жилийн ажлын горим	Тасралтгүй		
2	Жилийн календарьт хугацаа	хоног	365	
3	Жилд ногдох ажлын бус хоног	хоног	30	Баяр ёслол
4	Цаг агаарын саатал хүндрэл	хоног	5	
5	Жилд ажиллах хоног	хоног	308	
6	Хоногийн ажлын горим	ээлж	2	
7	Ээлжийн хугацаа	цаг	12	

Ажиллах хүчний мэдээлэл: Уурхай нь 2025 оны бүтэц орон тоогоор 250 хүний бүрэлдэхүүнтэй батлагдсан. Одоогийн байдлаар нэг ээлжинд 40-45 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагааг явуулж байна.

Уурхайн нүүрс олборлолт болон тээвэрлэлт: 2025 оны 10-р сарын 01-ны өдрийн байдлаар Хөөтийн уурхайн өөрийн үйлдвэрүүд болон уурхайн ам нөхцөлөөр нийт 99,9 мян.тн нүүрсийг худалдан борлуулсан байна. Нүүрс олборлолт, борлуулалтын ажилд САТ-395, САТ-773Е зэрэг экскаватор автосамосвал ажилласан. Өөрсдийн үйлдвэрийн нүүрс тээвэрлэлтийг гадны гэрээт компаниар гүйцэтгүүлж байна.

Уурхайд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмж: 2025 онд уурхайн ажилд хэрэглэгдэж буй тоног төхөөрөмжүүдийг хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4: Уурхайд ажиллаж буй техникүүдийн жагсаалт

№	Төрөл	Марк	Хүчин чадал	Тоо/ ширхэг	Зориулалт
1	Экскаватор	Комацу PC 1250-11	7.1 м³	1	Хөрс хуулалт
2	Экскаватор	САТ-395	6.1 м³	1	Нүүрс олборлолтонд ачилт хийх
3	Автосамосвал	75135	110 тн	2	Хөрс болон нүүрсний цэвэрлэгээ тээвэрлэх
4	Автосамосвал	САТ-773Е	60 тн	3	Хөрс, нүүрс олборлолт, нүүрсний цэвэрлэгээ тээвэрлэнэ
5	Белаз	76473	32 тн	1	Зам талбай услах, чийгшүүлж тоос дарах
6	Бульдозер	CAT D9R	18.5 м³	1	Шимт хөрс хуулалт, ул таазны цэвэрлэгээ болон овоолгын ажилд
7	Автогрейдер	Комацу GD825-а		1	Овоолго, зам болон мөргөцгийг тэгшлэх

Дээрх уулын ажлын зориулалттай техникүүдээс гадна түлшний хангамжинд хэрэглэх түлшний тэрэг болон олон төрлийн үйлчилгээний зориулалттай машин, тоног төхөөрөмжийг уурхайн бусад хэрэглээнд ажиллаж байна.

Уурхайн барилга байгууламж: Төслийн талбайд дараах барилга байгууламжууд байна:

- Ажилчдын амрах байр, бусад барилга байгууламж

- Оффис, сургалтын өрөө
- Зоогийн газар
- Халуун ус, хувцас угаалгын байр
- Засвар үйлчилгээний хэсэг-хаягдал тос хадгалах түр цэг
- Сэлбэг хэрэгслийн агуулах
- Насосчны байр
- Авто-пүү
- Шатахуун түгээгүүр
- Хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах цэг
- Ус цэвэршүүлэх, бохир ус цэвэрлэх байгууламж гэх мэт

Уурхайн цахилгаан хангамж: Шивээ-Говь 35кВ ЦДАШ нь Хөөтийн уурхайгаас 26км зайд байрлах Баянжаргалан сумын 35/15/10кВ дэд станцыг тэжээнэ. Үүнээс Хөөтийн уурхайн 35/6 дэд станц нь 3 гаралттай тэжээгдэж уурхайн засвар үйлчилгээний төв, ажилчдын хотхон болон зэрэгцээ үйл ажиллагаа явуулдаг Биг Могул уурхайг тус тус цахилгаан эрчим хүчээр хангаж байна.




Зураг 1: Хөөтийн уурхайн цахилгаан дамжуулах 35кВ дэд станц

Унд ахуйн ус: Хөөтийн хотгорын хэмжээнд хийсэн хайгуулын өрөмдлөгийн цооногт гүний ус илэрдэг боловч эрдэжилт ихтэй тул ундны болон техникийн хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй. Иймээс уурхайгаас 26км зайд байрлах Баянжаргалан сумын худгаас унд ахуйн усыг зөөврөөр хангаж 4 сараас цэвэршүүлэх байгууламж ашиглалтанд орж уурхайн гүний худгаас усаа хангаж байна.

Тайлант оны 10-р сарын 1-ний өдрийн байдлаар унд ахуйд нийт 1479 тн, ногоон байгууламжийн усалгаанд 110 тн ус ашигласан байна.

График 1. Унд, ахуйн усны хэрэглээ



Шүүрлийн ус: 4 дүгээр сараас эхлэн сумын Байгаль орчны мэргэжилтнийг байлцуулан уурхайгаас ус шавхан зайлуулах хэсэгт байршуулсан насост тоолуур суурилуулан шүүрлийн ус шавхан зайлуулах ажлыг эхлүүлсэн. Бид усны тухай хуулийн 30.1.4 дэх заалтын дагуу уурхайн шүүрлийн усыг шавхан зайлуулах хэсэгт Стандарт хэмжилзүйн газраар баталгаажуулсан тоолуур суурьлуулсан бөгөөд сар бүр сумын Байгаль орчны мэргэжилтнээр уурхайгаас шавхан зайлуулсан шүүрлийн усны хэмжээ, тоолуурын заалтыг хянуулан акт үйлдэж байна.

Доорх графикаас тайлант оны IV сараас IX сарын турш шавхан зайлуулсан шүүрлийн усны хэмжээ болон шүүрлийн ус ашиглалтын хэмжээг харна уу.

График 2. Шүүрлийн ус шавхан зайлуулсан хэмжээ ба түүний ашиглалт





График 3. Шүүрлийн ус шавхан зайлуулсан хэмжээ ба нийт ашигласан усны хэмжээ



Ил зумфпны гүн нь 1.5м, өргөн нь 2.5м бөгөөд дээр дурдагдсан усны насосаар соруулж 32тн-ийн Белазаар 16м өргөнтэй, 1.0-2.5км урт ил уурхайн доторх зам болон уурхайгаас овоолго хүрэх зам талбайг өдөрт 1-3 рейсийн давтамжтайгаар усалж тоосжилтыг дарж, ногоон байгууламжийн усалгаа болон бусад ажилд ашигласан.

Тайлант оны IV-IX сарын хооронд нийт 60,267 м³ ус шавхан зайлуулсан бөгөөд үүнээс 7876м³ усыг зам усалгаанд, 2944м³ усыг ногоон байгууламж услахад, 160м³ усыг бусад /бетон зуурах/ ажилд зарцуулсан нь нийт шавхан зайлуулсан усны 15%-ийг /10980м³/ эзэлж байна.

3. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаанаас агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тоосжилт, хорт хий, утаа, нүүрсний тоосонцор байж болох юм. Уурхайн байрлаж буй хэсэг нь хуурай уур амьсгалтай, салхи шуурга ихтэй, говь цөлийн бүс бөгөөд ургамлан бүрхэвч тачир сийрэг, нимгэн давхаргатай хөрс тул тоосжилт ихээр үүсэх боломжтой юм. Хөрс хуулалт, хөрсний догол, мөргөцөг гаргах, мөн олборлолт хийх зэрэг ажлууд хийх явцад агаарт үүсэх их хэмжээний тоос, салхи, шуургаар дамжин тархалт ихэснэ. Говийн нөхцөлд салхины хурдны давтагдал их байдаг нь ордын үйл ажиллагааны нөлөөгөөр газрын хөрснөөс суларсан шороо хийсч агаар бохирдуулах нь ихсэж болзошгүй юм.

Хөрсний чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хөөтийн уурхай орчмын хөрс нь шим тэжээлийн түвшингээр тааруу, ялзмагийн агууламж бага 0.24-2.96%, элсэнцэр, элсэрхэг хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учир элэгдэл эвдрэлд орохдоо амархан хөрс юм. Уулын малталт, олборлолтын ажлын талбайг бэлтгэх, зам шинээр гаргах зэрэг хөрсний өнгөн хуулалт хийх, газар шорооны ажлыг эхлүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор

хөрс эвдэрч элэгдэлд орно. Уурхайд ашиглагдаж байгаа хүнд машин механизмын хөдөлгөөн, түрэлтээр орчны хөрсний үе давхаргууд гэмтэж, бороо хур ихтэй үед хөрсөн дээр хонхор үүсч хөрс эвдрэх магадлалтай.

Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Усны эх үүсвэр болох худгийн ойр орчимд гүний усыг бохирдуулах үйл ажиллагаа явуулах, урсгалын эхэнд ус бохирдуулах үйл ажиллагаа явуулах (машин угаах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях), шатах тослох материал хөрсөнд асгарах зэрэг нь хөрсний сул ус болон хур тунадсаар дамжиж ундны ус цаашлаад гүний усыг бохирдуулж болзошгүй.

Амьтан, ургамлын зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хөрс хуулалт болон тэсэлгээ, нүүрс тээврийн үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд орж ургамлан нөмрөг, тэжээллэг ашигт ургамлын зүйл буурах аажмаар алга болох эрсдэлтэй. Нүүрс олборлолт, тээврийн үед их хэмжээгээр тоосонцор агаарт дэгдэх үед нарны цацрагийн шууд тусгалыг хаах түүний нөлөөгөөр ургамлын ургалт багасч анхдагч бүтээгдэхүүний бүтээмж буурах магадлалтай. Буурсан тохиолдолд идэш тэжээлийн гинжин хэлхээнд өөрчлөлт орох, амьтад идэш тэжээлээ даган нүүдэллэх тухайн нутгаас даажих, хэрвээ идэш тэжээлээр дамжин хүнд металл болон химийн хорт нэгдлүүд амьтны биед орсон тохиолдолд тэдгээрийн генийн санд өөрчлөлт орох гэх мэт эрсдэл гарч болзошгүй юм.

4. ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Дундговь аймгийн Баянжаргалан суманд орших Хөөтийн нүүрсний ил уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлав. Түүний дагуу тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг нэг бүрчлэн тодорхойлж, хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

2025 оны Хөөтийн уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал:

- “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг дэмжих, мөн уурхайн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй ургамлан нөмрөгийн талхалалт болон тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн хотхоны гадна болон дотоод талбайд 2 төрлийн нийт 1100 ширхэг мод тарьсан.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баянжаргалан сумын хогийн цэгт алсын зайн хяналт хийх зориулалттай нарны эрчим хүчээр ажилладаг, өдрийн цагаар 200-300м, шөнийн цагаар 150м хүртэлх зайг харах боломжтой, 4МР өндөр нягтралтай, 360° эргэдэг, хөдөлгөөн мэдэрч хөдөлдөг, бороо усны хамгаалалттай, -30° хүйтэнд тэсвэртэй 1 ширхэг камер,

анхааруулах, хориглох мэдээлэл бүхий 3 ширхэг самбарыг суурилуулан орон нутагт хүлээлгэн өгсөн .

- Хөөтийн уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, бууруулах зорилгоор агаарын чанар, газрын доорх ус, хөрсөн бүрхэвч зэрэг чиглэлээр орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

Хүснэгт 5. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт

Л/д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	10	9	1
2	Нөхөн сэргээлт	1	1	-
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	1	1	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	Ажил төлөвлөөгүй.	Ажил төлөвлөөгүй.	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Ажил төлөвлөөгүй.	Ажил төлөвлөөгүй.	-
6	Осол эрсдэлийн менежмент	4	4	-
7	Хог хаягдлын менежмент	4	3	1
8	Байгаль орчны төлөвлөгөөт аудит	1	1	
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	15	15	-
10	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	7	5	2
11	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	2	2	-
	Нийт	45	41	4

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Тоосжилтын эх үүсвэрүүдийг чийгшүүлэх	Төслийн талбай	Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн дотоод зам талбайн усалгааг 32тн усны белазаар өдөрт 1-4 удаагийн давтамжтай хийсэн.	809,856.0	Жилийн турш
Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					

2	Уурхайн шүүрлийн усны тоолуурыг суурилуулах, салгах тохиолдолд сумын байгаль орчны мэргэжилтнийг байлцуулах, шавхсан усыг автозамын усалгаанд эргүүлэн ашиглах	Төслийн талбайд	Шүүрлийн усны тоолуурыг 4-р сарын 22-ний өдөр сумын байгаль орчны мэргэжилтэнийг байлцуулан суурилуулсан ба усыг зам, ногоон байгууламжийн усалгаанд ашигласан.	-	Тухай бүрт
3	Уурхайн ойролцоох малчдын худаг, уурхайн талбайд байрлах хяналтын цооногууд дээр түвшний бууралтыг хянаж хэмжилт хийх, үр дүнг нэгтгэх	Төслийн талбай, Малчны худаг	Уурхайн хяналтын цооногууд болон малчны худагт усны түвшний бууралтыг хянаж хэмжилт хийсэн	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
4	ШТМ-ын хадгалалт, асгаралтанд хяналт тавих, асгаралт үүссэн тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан саармагжуулах.	Уурхайн талбай	Өдөр бүр ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, техникийн бүрэн бүтэн байдлыг шалгадаг ба засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас шатах тослох материал хөрсөнд асгарсан тохиолдолд тэр даруй саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авч ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
5	Уурхайн болон тээврийн замын урсгал засваруудыг цаг тухайд нь хийх	Уурхайгаас Баянжаргалан сум хүртлэх тээврийн зам	Уурхайн дотоод зам, нүүрс тээврийн замыг тогтмол хусаж сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
6	Уурхайн олборлотын явцад хуулсан шимт хөрсийг стандартын дагуу хадгалж, овоолго үүсгэн салхинд хийсэх, усанд автах, хаягдал чулуулгийн овоолго болон бусад материалаар бохирдохоос хамгаалж, бүртгэл мэдээлэлийг сайжруулах	Шимт хөрсний овоолго	Монгол Улсын стандарт MNS 5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалтын дагуу шимт хөрсний овоолгыг үүсгэсэн. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, харилцан адилгүй тогтоосон гүн хүртэл шимт хөрсийг хуулж хадгалж, чанарын хяналт хийж гүйцэтгэв.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
7	Уурхайн суурингийн ногоон байгууламжийг арчлан тордож, ногоон	Уурхайн талбай	Уурхайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэхээр 2 төрлийн 800 ширхэг модыг хотхоны зам дагуу болон засвар	8,087,500.0	Жилдээ

	байгууламжийг нэмэгдүүлэх		үйлчилгээний төв тариалсан ба усалгаа арчилгааг 4 сараас хийж эхэлсэн.		
8	Сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Орон нутгаас зааж өгсөн талбайд	Уурхайн нийгмийн хариуцлагын хүрээнд тус сумын наадмын талбайн баруун хойд хэсэгт 300 ширхэг мод тарьж сумын байгаль орчны мэргэжилтэн акт үйлдэж хүлээлгэнэ өгсөн.	2,394000	1 удаа
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
9	Цаг агаар хүндэрч бэлчээр нутгийн ан амьтан идэш тэжээлээр дутмаг үед мал амьтдад өвс, тэжээл тавьж өгөх зэргээр зориудын тэтгэх (биотехникийн) арга хэмжээ авах	Бага газрын чулуу ТХГН	Ан амьтдыг биотехникийн аргаар тэтгэх ажлын хүрээнд өвсний захиалгыг хийсэн, Захиалгын барааг хүлээнэ ажиллаж байна	-	Жилийн турш
10	Уурхайн талбай орчимд харагдсан амьтадын бүртгэлийг уурхайн ажилчдын оролцоотойгоор бүртгэн амьтдын тархалт, байршлын талаар мэдээллийг цуглуулах	Уурхайн орчимд	Уурхайн талбайн орчимд үзэгдсэн амьтдын бүртгэлийг хийж сар бүр ERP системд оруулан мэдээллийн сан үүсгэсэн	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
Нийт зардал				11,291,000	

5.1 Тоосжилтын эх үүсвэрүүдийг чийгшүүлэх

Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн дотоод зам талбайн усалгааг 32тн усны белазаар өдөрт 1-4 удаагийн давтамжтай хийсэн ба нийт 7876 м³ шүүрлийн ус ашигласан.



Зураг 2. Уурхайн зам талбайг усны белазаар усалж замын тоосыг дарж байгаа нь.

5.2 Уурхайн шүүрлийн усны тоолуурыг суурилуулах, салгах тохиолдолд сумын байгаль орчны мэргэжилтнийг байлцуулах, шавхсан усыг автозамын усалгаанд эргүүлэн ашиглах

2025 оны 04 дугаар сарын 22-ний өдөр шүүрлийн усны 100м^3 цагийн хэмжих хязгаартай 150мм голчтой тоолуурыг Баянжаргалан сумын Байгаль орчны мэргэжилтнийг байлцуулан суурилуулж шүүрлийн усыг шавхан зайлуулах ажил эхэлсэн.

Шүүрлийн усыг өдөр бүр шавхан зайлуулдаг ба усыг зам, талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашигладаг. /Тоолуур суурилуулсан актыг ЭНД дарж харна уу./



Зураг 3. Шүүрлийн усны насост тоолуур суурьлуулж байгаа нь

5.3 Уурхайн ойролцоох малчдын худаг, уурхайн талбайд байрлах хяналтын цоонууд дээр түвшний бууралтыг хянаж хэмжилт хийх, үр дүнг нэгтгэх


Уурхайн хяналтын цоонууд болон малчны худагт сар бүр усны түвшний бууралтыг хянаж хэмжилт хийсэн.

Хүснэгт 7. Гүний худгийн түвшин хэмжилт

№	Огноо	Координат	Худгийн нэр	Хэмжилт /м/
1	2025.09.22	45°41'00.23" N, 107°41'49.21" E	Kh-01/2023 хотхон	10.6
2		45°41'29.65" N, 107°40'51.33" E	Kh-03/2023 индер	27
3		45°41'42.68" N, 107°40'43.48" E	Kh-02/2023 зүт	31.6
4		45°46'02.0" N, 107°42'48.5" E	Малчны худаг	22
1	2025.10.09	45°41'00.23" N, 107°41'49.21" E	Kh-01/2023 хотхон	11.8
2		45°41'29.65" N, 107°40'51.33" E	Kh-03/2023 индер	26
3		45°41'42.68" N, 107°40'43.48" E	Kh-02/2023 зүт	29

4		45°46'02.0" N, 107°42'48.5" E	Малчны худаг	18
---	--	----------------------------------	--------------	----

График 4. Гүний худгийн түвшин хэмжилтийн харьцуулалт



Зураг 4. Гүний худгийн түвшин хэмжиж буй байдал

5.4 ШТМ-ын хадгалалт, асгаралтанд хяналт тавих, асгаралт үүссэн тохиолдолд бохирдсон хөрсийг хуулан саармагжуулах

Уурхайн үйл ажиллагаанаас үүссэн 6,4тн ШТМ-г уурхайн засвар үйлчилгээний төвийн гадна талбайд зориулалтын түр цэгт хадгалан тусгай зөвшөөрөл бүхий Об ойл индастриал ХХК-д шилжүүлсэн

Мөн өдөр бүр ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, техникийн бүрэн бүтэн байдлыг шалгадаг. Тайлант онд засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас 1 удаагийн асгаралт үүссэн ба бохирдсон хөрсийг хуулж цэвэрлэн, саармаг жуулах арга хэмжээ авч ажилласан.



Зураг 5. Бохирдсон хөрс хуулж цэвэрлэж байгаа болон бохирдсон хөрс саармагжуулах бодис

5.5 Уурхайн болон тээврийн замын урсгал засваруудыг цаг тухайд нь хийх

Уурхайн дотоод зам талбай болон нүүрс тээврийн зам засварыг өөрсдийн техник болох автогрейдер, хово автосамосвал зэрэг техникүүдээр тогтмол хусаж сайжруулдаг ба олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж замын хажуугаар шуудуу, хашлага үүсгэсэн.



Зураг 6. Нүүрс тээврийн зам хусаж сайжруулж байгаа нь

5.6 Уурхайн олборлолтын явцад хуулсан шимт хөрсийг стандартын дагуу хадгалж, овоолго үүсгэн салхинд хийсэх, усанд автах, хаягдал чулуулгийн овоолго болон бусад материалаар бохирдохоос хамгаалах

Монгол Улсын стандарт MNS 5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалтын дагуу шимт хөрсний овоолгыг үүсгэсэн. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, харилцан адилгүй тогтоосон гүн хүртэл шимт хөрсийг хуулж хадгалж, чанарын хяналт хийж гүйцэтгэв.



Зураг 7. Шимт хөрсний талбай бэлдсэн байдал

5.7 Уурхайн суурингийн ногоон байгууламжийг арчлан тордож, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

Уурхайн ногоон байгууламжийн усалгаа арчилгааг 4 сараас эхлүүлсэн ба ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор уурхайн зам дагуу болон нөхөн тарилтаар нийт 700 ширхэг хайлаас мод, Засвар үйлчилгээний төвийн зүүн хойд талд 100 ширхэг улиас тарьсан. Уурхайн ногоон байгууламж 98,0% ургалтай байна.



Зураг 8. Ногоон байгууламжийн мод тарьж буй байдал

5.8 Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

Тус сумын надмын талбайн баруун хойд хэсэгт 2025 оны 05 сарын 20-ний өдөр 300 ширхэг хайлаас мод нөхөн тарилтаар тарьж усалгааг хийв.



Зураг 9. Суманд мод тарьсан зураг

5.9 Уурхайн талбай орчимд харагдсан амьтдын бүртгэлийг уурхайн ажилчдын оролцоотойгоор бүртгэн амьтдын тархалт, байршлын талаар мэдээллийг цуглуулах

Уурхайн нийт ажилчдад байгаль орчны сургалтаар амьтны үзэгдлийг мэдээллэх бүртгэл хийх талаар танилцуулан уурхайн орчим үзэгдсэн амьтдын бүртгэлийг хийж сар бүр ERP системд оруулан мэдээллийн сан үүсгэсэн. 10 дугаар сарын 1-ний өдрийн байдлар нийт 50 бодгаль бүртгэгдсэн ба туулай, зараа, гүрвэл, бор шувуу элбэг тааралдсан.

#	Урьдчилсан	Огноо	Амьтан	Хэрэгсэл	Бүртгэл	Тайлбар
1	Уурхайн талбай	2024.08.08.00	Бүтэц	1	Таруулах	ERP системд оруулсан
2	Уурхайн талбай	2024.08.08.00	Бүтэц	1	Таруулах	ERP системд оруулсан
3	Уурхайн талбай	2024.08.08.00	Шувуу	1	Таруулах	ERP системд оруулсан
4	Уурхайн талбай	2024.08.08.00	Хүрлэн	1	Таруулах	ERP системд оруулсан
5	Уурхайн талбай	2024.08.08.00	Шувуу	1	Таруулах	ERP системд оруулсан
6	Уурхайн талбай	2024.08.08.00	Хүрлэн	1	Таруулах	ERP системд оруулсан
7	Уурхайн талбай	2024.08.08.00	Шувуу	1	Таруулах	ERP системд оруулсан
8	Уурхайн талбай	2024.08.08.00	Хүрлэн	1	Таруулах	ERP системд оруулсан
9	Уурхайн талбай	2024.08.08.00	Шувуу	1	Таруулах	ERP системд оруулсан
10	Уурхайн талбай	2024.08.08.00	Хүрлэн	1	Таруулах	ERP системд оруулсан
11	Уурхайн талбай	2024.08.08.00	Шувуу	1	Таруулах	ERP системд оруулсан
12	Уурхайн талбай	2024.08.08.00	Хүрлэн	1	Таруулах	ERP системд оруулсан
13	Уурхайн талбай	2024.08.08.00	Шувуу	1	Таруулах	ERP системд оруулсан
14	Уурхайн талбай	2024.08.08.00	Хүрлэн	1	Таруулах	ERP системд оруулсан
15	Уурхайн талбай	2024.08.08.00	Шувуу	1	Таруулах	ERP системд оруулсан
16	Уурхайн талбай	2024.08.08.00	Хүрлэн	1	Таруулах	ERP системд оруулсан
17	Уурхайн талбай	2024.08.08.00	Шувуу	1	Таруулах	ERP системд оруулсан
18	Уурхайн талбай	2024.08.08.00	Хүрлэн	1	Таруулах	ERP системд оруулсан
19	Уурхайн талбай	2024.08.08.00	Шувуу	1	Таруулах	ERP системд оруулсан
20	Уурхайн талбай	2024.08.08.00	Хүрлэн	1	Таруулах	ERP системд оруулсан



Зураг 11. Амьтны үзэгдэл болон ERP системд бүртгэгдсэн байдал

6. НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 8. Нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг	Уурхайн хэмжээнд	Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг	Үйл ажиллагааны зардлаас	Тухайн жилдээ

тусгай байршуулах	дансанд		БОАЖЯ-ны тусгай дансанд байршуулсан.		
Нийт зардал					

6.1 Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг тусгай дансанд байршуулах

Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал болох 12,135,000 төгрөгийг БОАЖЯ-ны тусгай дансанд байршуулсан. /Гүйлгээ хийсэн баримтыг [ЭНД](#) дарж харна уу./

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Баянжаргалан сумын хогийн цэгийн шинэчлэл сайжруулалтыг хийж хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх	Орон нутгийн саналын дагуу	Баянжаргалан сумын хогийн цэгт алсын зайн хяналт хийх зориулалттай нарны эрчим хүчээр ажилладаг, 1 ширхэг камер, анхааруулах, хориглох мэдээлэл бүхий 3 ширхэг самбарыг суурилуулсан	10,400,000	Тухайн жилдээ
Нийт зардал				10,400,000	

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан сумын хогийн цэгт алсын зайн хяналт хийх зориулалттай нарны эрчим хүчээр ажилладаг, өдрийн цагаар 200-300м, шөнийн цагаар 150м хүртэлх зайг харах боломжтой, 4МР өндөр нягтралтай, 360° эргэдэг, хөдөлгөөн мэдэрч хөдөлдөг, бороо усны хамгаалалттай, -30° хүйтэнд тэсвэртэй 1 ширхэг камер, анхааруулах, хориглох мэдээлэл бүхий 3 ширхэг самбарыг суурилуулан орон нутагт хүлээлгэн өгсөн. /Орон нутагт хүлээлгэн өгсөн актыг [ЭНД](#) дарж харна уу./





Зураг 12. Шинэ хогийн цэг болон хашаажуулалт хийсэн байдал

8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нөлөөллийн бүсийн иргэнтэй нөхөн олговор олгох гэрээг хийж 2023 онд шийдвэрлэсэн.

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй тул арга хэмжээ төлөвлөөгүй болно.

10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг ханган ажиллах	Нийт ажилтан	Цахилгааны эвдрэл гэмтлийг цахилгааны инженер, цахилгаанчин, диспичерүүд засаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан болон давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах, бүртгэлжүүлэх	Нийт ажилтан	ХАБЭА болон Байгаль орчны ээлжит, ээлжит бус болон ажлын байрны анхан шатны зааварчилгааг улирал тутам болон шаардлагатай тохиолдол бүрт орж бүртгэл хөтөлсөн.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
3	Хөдөлмөр хамгаалал, байгаль орчны чиглэлээр үзлэг шалгалт хийж уурхайн удирдлагад тайлагнаж, үл тохирлыг арилгаж ажиллах	Нийт ажилтан	Улиралд нэг удаа хөдөлмөр хамгаалал, байгаль орчин, цахилгаан, эрүүл ахуйн нэгдсэн үзлэг шалгалтыг зохион байгуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт

4	Үер ус, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, ажилчдад сэрэмжлүүлэг мэдээлэл өгөх	Нийт ажилтан	Цаг агаарын урьдчилсан мэдээг 7 хоног бүр гаргаж цахим сүлжээгээр нийт ажилчдад танилцуулдаг.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
Нийт зардал				-	

10.1 Өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг ханган ажиллах

Цахилгааны эвдрэл гэмтлийг цахилгааны инженер, цахилгаанчин, диспичерүүд хариуцан засах ба Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан болон давтан зааварчилгаа, цахилгаан аюулгүй байдлын сургалтаар мэргэжлийн бус хүн цахилгаан, өндөр хүчдэлтэй харьцан ажиллахыг хориглох талаар сургалтыг нийт ажилчдад орж танилцуулан хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.

10.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан болон давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах, бүртгэлжүүлэх

Манай байгууллага нь MNS 4969:2000 стандарт болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/173 тоот тушаалаар компанийн нийт ажилчдад ХАБЭА-н сургалт, зааварчилгааг байнга орж ажилладаг. Үүнд:

Хүснэгт 11: Хөдөлмөр хамгааллын чиглэлээр ордог сургалт, түүний давтамж

	ХАБЭА зааварчилгаа		Давтамж
1	Урьдчилсан зааварчилгаа		Шинэ ажилчдад
2	Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа		Шинэ болон ажлын байрны нөхцөл өөрчлөгдсөн
3	Давтан зааварчилгаа	Ээлжит	Улирал тутам
4		Ээлжит бус	Тухай бүрт
5		Өдөр тутмын	Өдөр бүр
6	Шинэ ажилтны сургалт		Шинэ ажилчдад
7	Нийт ажилтны сургалт		Жилд 2 удаа
8	Ажил олгогчийн сургалт		Жилд 1 удаа
9	Эрсдэлтэй ажлын байрны сургалт		Жилд 1 удаа
	Тусгай сургалт		Тухай бүрт



Хүснэгтэд харуулснаар Байгаль орчин болон Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зааварчилгааг орж бүртгэл хөтөлдөг. Тайлант оны 10-р сарын 23-ны өдрийн байдлаар нийт 95 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 3,993 хүн хамрагдсан байна.



Зураг 13. Сургалт орж буй байдал

10.3 Хөдөлмөр хамгаалал, байгаль орчны чиглэлээр үзлэг шалгалт хийж уурхайн удирдлагад тайлагнаж, үл тохирлыг арилгаж ажиллах

Байгаль орчны үзлэг шалгалт хийх хуваарийг уурхайн даргаар батлуулж хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн. Мөн улирал тутамд хөдөлмөр хамгаалал, байгаль орчин, цахилгаан, эрүүл ахуйн нэгдсэн үзлэг шалгалтыг хийж зөрчил дутагдлыг илрүүлэн танилцуулга бэлтгэн уурхайн удирдлагад танилцуулж харьяалах хэсгүүдэд хугацаатай үүрэг өгч үл тохиролуудыг арилгуулан ажилласан.



Зураг 14. Үзлэг шалгалтын хуваарь болон тайлан

10.4 Үер ус, салхи шуурга, аянга цахилгаан, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, ажилчдад сэрэмжлүүлэг мэдээлэл өгөх

Цаг агаарын урьдчилсан мэдээг 7 хоног бүр гаргаж цахим сүлжээгээр нийт ажилчдад танилцуулдаг ба онцгой анхааруулах мэдээг уурхайн группт байршуулдаг.



Зураг 15. Цаг агаарын мэдээг цахимаар ирүүлж буй байдал

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт



№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Хог хаягдлын гэрээ байгуулах, үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах	Уурхайн хэмжээнд	2025 оны 2-р сард Сумын Засаг даргатай хог хаягдлын гэрээг байгуулан үүссэн хог хаягдлаа сумын төвийн хогийн цэгт хаяж байна.	990,000.0	Жилдээ
2	Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах		Уурхайн 2 ээлжийн нийт ажилчдад “Хог хаягдлын менежмент”-ийн сургалтыг зохион байгуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
3	Үүсэх хог хаягдлыг ангилан ялгаж дахивар авах цэгт хүлээлгэн өгөх		Дахивар хаягдал болох хуванцар сав, шилийг ангилан ялгаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
4	Тос тосолгооны материалын үлдэгдэл хаягдлыг ил задгай хаяхгүй байх, тусгай талбайд зориулалтын битүүмжлэлтэй цэгт хуримтлуулах, мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх		Хаягдал тос маслыг аюултай хог хаягдал түр хадгалах цэгт хадгалан бүртгэл хөтөлж Об ойл индастриал ХХК-д шилжүүлсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр
Нийт зардал				990,000.0	

11.1 Хог хаягдлын гэрээ байгуулах, үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах

2025 оны 2-р сард Баянжаргалан сумын Засаг даргатай хог хаягдлын гэрээг байгуулан үүссэн хог хаягдлаа сумын төвийн хогийн цэгт хаяж байна. /Хог хаягдлын гэрээ төлбөрийн баримтыг [ЭНД](#) дарж харна уу./

11.2 Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах

Уурхайн нийт ажилчдад байгаль орчны бохирдлоос урьчилан сэргийлэх, үүсч буй хог хаягдлаа хэрхэн бууруулах, ангилан ялгах талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан. 10 удаагийн сургалтанд давхардсан тоогоор нийт 105 ажилтан хамрагдсан.



Зураг 16. Хог хаягдлын сургалт орж буй байдал

11.3 Тос тосолгооны материалын үлдэгдэл хаягдлыг ил задгай хаяхгүй байх, тусгай талбайд зориулалтын битүүмжлэлтэй цэгт хуримтлуулах, мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөх

Засвар үйлчилгээний төвөөс үүсч буй аюултай хог хаягдлыг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгалж, сар бүр бүртгэл хөтлөдөг. Тайлант онд уурхайн аюултай хог хаягдал түр хадгалах цэгт төвлөрсөн 6,4 тн хаягдал тос маслыг аюултай хог хаягдал дахин боловсруулах, устгах тусгай зөвшөөрөлтэй Об ойл индустриал ХХК-д хүлээлгэн өгсөн. /Аюултай хог хаягдлын гэрээ, дагалдах маягтыг ЭНД дарж харна уу/



Зураг 17. Хаягдал тос масло хүлээлгэн өгсөн байдал

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

12.1 Усны хяналт шинжилгээ

Хүснэгт 13. Усны хяналт шинжилгээний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Ca, Mg, CL, SO4, NO2, K агууламж, амт, үнэр, өнгө, pH нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг	Унд, шүүрлийн ус, Хөөтийн булаг	Унд, шүүрэл, Хөөтийн булгийн уснаас дээж авч Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор химийн шинжилгээг гүйцэтгүүлсэн.	363,000.0	Жилд 2 удаа
Усны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал				363,000.0	

Уурхайн ундны уснаас 5, 9-р сард дээж авч итгэмжлэгдсэн Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор ерөнхий химийн шинжилгээг хийлгүүлэв. Шинжилгээний дүнг MNS0900:2018 “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага” стандарттай харьцууллаа.

Хүснэгт 14. Ундны усны-химийн үзүүлэлтийн шинжилгээний дүн

Шинжилгээний дүнг MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй

Үзүүлэлт	MNS 900:2018 ЗДХ	Ундны ус	
		2025.05 сар	2025.9 сар
рН-Усны орчин	6.5-8.5	6.3	7.20
Цахилгаан дамжуулах чанар мСм\см	-	322	2870
Ерөнхий хатуулаг мг-экв\л	<7.0	1.8	24.7
Кальци, (Ca ²⁺) мг\л	<100.0	20.3	152.3
Магни, (Mg ²⁺) мг\л	<30.0	9.0	207.9
Фосфатын ион, (PO ₄ ³⁻) мг\л	3.5	0.041	0.004
Хлорид (Cl) мг\л	<350.0	16.8	127.6
Гидрокарбонат (HCO ₃) мг\л	-	148.9	1678.0
Нитритийн ион (NO ₂), мг\л	<1.0	0.002	Илрээгүй
Нитрат (NO ₃), мг\л	<50.0	1.21	0.45
Сульфат, (SO ₄) мг\л	<500.0	26.9	240.1
Төмөр (Fe), мг\л	0.3	0.06	0.04
Натри, Кали (Na, K) мг\л	<200	43.0	285.0
Аммони, (NH ₄) мг\л	<1.5	0.01	1.14
Жинлэгдэх бодис (Ж/Б) мг\л	-	4.6	1.2
Перманганатын исэлдэх чадвар (ПИЧ) мг\л	-	0.2	0.5
Фтор (F ⁻) мг\л	-	0.22	1.07
Эрдэжилт мг\л	-	265.0	2690.9

байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарттай харьцуулахад магни, хатуулаг стандарт хэмжээнээс давсан байна. Энэ нь эрдэжилт ихтэй, шүлтлэг ус болохыг харуулж байна. (Лабораторийн шинжилгээний хариуг [ЭНД](#) дарж харна уу)

Уурхайн шүүрлийн уснаас 5, 9-р сард дээж авч итгэмжлэгдсэн Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор ерөнхий химийн шинжилгээг хийлгүүлэв. Шинжилгээний дүнг MNS 6148:2010 “Усны чанар. Газрын доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандарттай харьцууллаа.

Хүснэгт 15 . Шүүрлийн усны-химийн үзүүлэлтийн шинжилгээний дүн

Үзүүлэлт	MNS 6148:2010 ЗДХ	Шүүрлийн ус	
		2025.05 сар	2025.9 сар
рН-Усны орчин	6.5-8.5	7.2	7.76
Цахилгаан дамжуулах чанар мСм\см	-	6410	5000
Ерөнхий хатуулаг мг-экв\л	-	52.3	33.2
Кальци, (Ca ²⁺) мг\л	-	250.1	209.4
Магни, (Mg ²⁺) мг\л	-	483.7	277.2
Фосфат, (PO ₄ ³⁻) мг\л	3.5	0.022	0.007
Хлорид (Cl) мг\л	350	579.3	443.1
Гидрокарбонат (HCO ₃) мг\л	-	1293.6	884.8
Нитрит (NO ₂), мг\л	1.0	0.005	0.088
Нитрат (NO ₃), мг\л	50.0	0.65	1.57
Сульфат, (SO ₄) мг\л	500.0	1933.1	1832.9
Төмөр (Fe), мг\л	0.3	0.39	0.06
Натри, Кали (Na, K) мг\л	-	638.2	797.8

Аммони, (NH ₄) мг/л	3	2.02	1.88
Жинлэгдэх бодис (Ж/Б) мг/л	-	5.0	8.2
Перманганатын исэлдэх чадвар (ПИЧ) мг/л	-	3.3	3.2
Фтор (F ⁻) мг/л	-	1.70	0.62
Эрдэсжилт мг/л	-	5177.9	4445.3

Шинжилгээний дүнг MNS 6148:2010 “Усны чанар. Газрын доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандарттай харьцуулахад хлорид, сульфат ЗДХ-с давсан байна. (Лабораторийн шинжилгээний хариуг [ЭНД](#) дарж харна уу)

Хөөтийн булгийн уснаас 5, 9-р сард дээж авч итгэмжлэгдсэн Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор ерөнхий химийн шинжилгээг хийлгүүлэв. Шинжилгээний дүнг MNS 4586:1998 “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” стандарттай харьцууллаа.

Хүснэгт 16. Шүүрлийн усны-химийн үзүүлэлтийн шинжилгээний дүн

Үзүүлэлт	MNS 4586:1998 ЗДХ	Булгийн ус	
		2025.05 сар	2025.9 сар
pH-Усны орчин	6.5-8.5	7.5	8
Цахилгаан дамжуулах чанар мСм\см	-	2560	1856
Ерөнхий хатуулаг мг-экв\л	-	20.7	17.85
Кальци, (Ca ²⁺) мг\л	-	164.1	80
Магни, (Mg ²⁺) мг\л	-	151.8	168.5
Фосфат, (PO ₄ ³⁻) мг\л	-	0.159	0.009
Хлорид (Cl) мг\л	300	168.4	152.4
Гидрокарбонат (HCO ₃) мг\л	-	1366.8	695.6
Нитрит (NO ₂), мг\л	0.02	0.003	0.002
Нитрат (NO ₃), мг\л	9	15.98	0.28
Сульфат, (SO ₄) мг\л	100	227.5	383.1
Төмөр (Fe), мг\л	-	0.68	0.09
Натри, Кали (Na, K) мг\л	-	280.4	145.8
Аммони, (NH ₄) мг\л	0.5	0.31	0.09
Жинлэгдэх бодис (Ж/Б) мг/л	-	1.6	29.4
Перманганатын исэлдэх чадвар (ПИЧ) мг/л	-	2.8	369
Фтор (F ⁻) мг/л	1.5	1.60	1.46
Эрдэсжилт мг/л	-	2359.0	1625.4

Шинжилгээний дүнг MNS 6148:2010 “Усны чанар. Газрын доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” стандарттай харьцуулахад сульфат, аммони ЗДХ-с давсан байна. (Лабораторийн шинжилгээний хариуг [ЭНД](#) дарж харна уу)



Зураг 18. Дээж авч буй байдал

12.2 Хөрсний хяналт шинжилгээ

Хүснэгт 17. Хөрсний хяналт шинжилгээний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Хөрсний хими физик шинж чанар	Шимт хөрсний овоолго, Уурхайн карьер, Хотхон, Хогийн цэг, ЗҮТ	Хөрсний агрохими, хүнд металлын шинжилгээг нийслэл болон Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор гүйцэтгүүлсэн.	830,000.0	Хавар, Намар
2	Хөрсний хүнд металл (Cr, Cd, Pb, Ni, Zn агууламж)		Хавар, Намар		
Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал				830,000.0	

13.2.1 Хөрсний агрохимийн шинжилгээ

Уурхайн хөрсний бохирдлыг хянах зорилгоор 5, 9-р сард дээж авч нийслэл болон Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор хийлгүүлсэн.

Хүснэгт 18. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн

Дээжний нэр		Хотхон	Шимт хөрсний овоолго	Уурхайн карьер	Хогийн цэг	ЗҮТ	Цэвэрлэх байгууламж
pH	2025.05	7.9	7.8	6.6	7.2	7.1	7.4
	2025.09	8.0	7.8	6.7	7.3	7.1	7.3
Ялзмаг %	2025.05	0.29	1.20	0.24	0.48	0.43	0.44
	2025.09	0.53	1.89	0.54	0.66	0.40	0.40
NO ₃ мг/кг	2025.05	8.6	31.5	15.6	18.7	6.4	29.8
	2025.09	11.2	31.7	12.9	5.72	8.6	19.5
NH ₄ мг/кг	2025.05	11.8	14.0	6.6	60.3	11.8	22.8
	2025.09	15.4	18.4	8.8	44.1	16.9	21.3
SO ₄ мг/кг	2025.05	119.4	751.6	1795.0	595.5	219.8	1669.0
	2025.09	263.2	809.9	1687.6	549.4	318.8	1622.5
P ₂ O ₅ мг/кг	2025.05	6.3	26.7	10.3	48.9	22.4	46.4
	2025.09	7.5	33.0	17.2	36.8	33.7	56.3

Шинжилгээний үр дүнг 05-р сар, 09 сарын шинжилгээний үр дүнтэй харьцуулан үзэхэд pH саармаг- сул шүтлэг, ялзмагийн хувьд органик бодис багатай, элэгдэл орсон хөрсний шинжтэй.

Фосфорын хэмжээ цэвэрлэх байгууламж орчимд хамгийн өндөр лаг бохир усны хаягдлын улмаас фосфор хуримтлагдаж байна. Хөрсний ерөнхий шинж чанар саармаг–сул шүлтлэг, органик бодис багатай, эрдэс давсны агууламж харилцан адилгүй байна. (Лабораторийн шинжилгээний хариуг [ЭНД](#) харна уу)

13.2.2 Хөрсний хүнд металлын шинжилгээ

Уурхайн хөрсний бохирдлыг хянах зорилгоор дээж авч нийслэл болон Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор хийлгэсэн.

Хүснэгт 19. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

№	Он	Цэгийн нэр	Hg	Cd	Pb	Cu	Zn	Cr	Sr
			ppm	ppm	ppm	ppm	ppm	ppm	ppm
1	2025.05	Шимт хөрсний овоолго	<0.005	0.8	22	28	82	<0.5	506
	2025.09		<0.005	<0.05	41	30	99	<0.5	562
2	2025.05	Хотхон	<0.005	<0.05	14	29	<0.5	<0.5	575
	2025.09		<0.005	<0.05	14	31	94	<0.5	559
3	2025.05	Уурхайн карьер	<0.005	<0.05	12	28	<0.5	<0.5	532
	2025.09		<0.005	<0.05	13	28	15	<0.5	500
4	2025.05	Хогийн цэг	<0.005	0.4	10	28	<0.5	<0.5	521
	2025.09		<0.005	<0.05	10	29	75	<0.5	545
5	2025.05	ЗҮТ	<0.005	0.9	14	27	28	<0.05	497
	2025.09		<0.005	<0.05	47	33	113	<0.5	728
6	2025.05	Цэвэрлэх байгууламж	<0.005	0.8	14	26	57	<0.5	540
	2025.09		<0.005	0.3	12	27	70	<0.5	505
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/			150	3,0	100,0	100,0	300,0	150,0	800,0
Хортой агууламж /MNS 5850:2019/			1000,0	10,0	500,0	400,0	500,0	600,0	3000,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/			1800,0	20,0	1200,0	1500,0	1000,0	1000,0	6000,0

Шинжилгээний дүнгээс харахад MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заагдсан хэмжээнд байна. (Лабораторийн шинжилгээний хариуг [ЭНД](#) харна уу)



Зураг 19. Хөрсний дээж авч буй байдал

13.3 Агаарын хяналт шинжилгээ

Хүснэгт 20. Агаарын хяналт шинжилгээний биелэлт


№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Тоосжилт	Технологийн зам, уурхайн карьер, ажилчдын хотхон, нөлөөллийн бүс	Тоосны концентрацийн хэмжилтийг 5, 9-р сард хийлгэсэн бөгөөд шинжилгээний дүнг доор дэлгэрэнгүй харуулав.	160,000.0	Хавар, намар
2	SO2, NO2		Агаарын чанарын шинжилгээг 5, 9-р сард хийлгэсэн бөгөөд шинжилгээний дүнг доор дэлгэрэнгүй харуулав.	196,000.0	
Агаарын чанарын хяналт шинжилгээний нийт зардал мян.төг				356,000.0	


Уурхайн гадаад орчны агаарын чанарын шинжилгээг Дундговь аймгийн УЦОШТөвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор хийлгэсэн. Ингэхдээ уурхайн карьер, технологийн зам гэсэн объектуудад угаарийн хий, азотын давхар исэл, агаарын нийт тоосонцрыг тодорхойлох шинжилгээнүүдийг хийлгэсэн бөгөөд шинжилгээний үзүүлэлтүүдийг агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулхад хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна. (Лабораторийн шинжилгээний хариуг [ЭНД](#) харна уу)

Хүснэгт 21. Агаарын шинжилгээний дүн

№	Сорьц авсан цэг	2025.05			2025.09		
		SO ₂ мг/м ³	NO ₂ мг/м ³	Нийт тоос мг/м ³	SO ₂ мг/м ³	NO ₂ мг/м ³	Нийт тоос мг/м ³
1	Уурхайн карьер	0.022	0.040	0.035	0.013	0.046	0.072
2	Засвар үйлчилгээний төв	0.018	0.026	0.028	0.019	0.030	0.058
3	Ажилчдын хотхон	0.016	0.022	0.021	0.011	0.039	0.027
4	Нөлөөллийн бүс	0.016	0.031	0.019	0.009	0.025	0.025
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016		0.450 мг/м³	0.20 мг/м³	0.50 мг/м³	0.450 мг/м³	0.20 мг/м³	0.50 мг/м³

График 5. Агаарын чанарын харьцуулалт





Зураг 20. Агаарын чанарын дээжлэлт хийж буй байдал

13.4 Ургамлан бүрхэвчийн судалгаа

Хүснэгт 22. Ургамлан бүрхэвчийн судалгааны биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо Дундаж өндөр, см Бүрхэц	Төслийн талбайд	Ургамлан бүрхэвчийн судалгааг мониторингийн 2 цэгт хийж гүйцэтгэсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилд 1 удаа
Нийт зардал				-	

Ургамлын судалгааг жилд нэг удаа 8 сард хийхээр төлөвлөсний дагуу 2025.08.21-ны өдөр раменскийн тор ашиглан MV-012199, MV-020297 тусгай зөвшөөрлийн талбайн ургамлын мониторингийн 2 цэгт хийж гүйцэтгэсэн. Ургамлан бүрхэвчийн судалгаагаар тухайн цэгүүд дахь ургамлын зүйлийн бүрдэл, бодгалийн тоо, газрын дээрх ургамлын өндөр болон бүрхэцийг тодорхойлох боломжтой.

Хүснэгт 23. Ургамлын зүйлийн бүрдэл

№	Мониторингийн цэгийн байршил	Ургамлын зүйл		Бодгалийн тоо	Амьдралын хэлбэр	Наслалт	Бодгалийн өндөр [см]	Ургамлын бүрхэц	Зүйлийн тоо
		Латин	Монгол						
1	MV-012199 45°41'26.52"N, 107°40'37.18"E	Allium polyrhizum	Таана	3	Өвслөг ургамал	Олон наст	18	54%	6
2		Reaumuria soongorica (Pall.)	Зүүнгарын улаан бударгана	2	Сөөглөг ургамал	Олон наст	6		
3		Artemisia scoparia Waldst. et Kit	Ямаан шарилж	7	Өвслөг ургамал	Нэг наст	24		
4		Cleistogenes squarrosa (Trin) Keng	Дэрвээн хазаар өвс	5	Өвслөг ургамал	Нэг наст	23		
5		Agropyron repens (L.)P.B.	Мөлхөө хиаг	1	Өвслөг ургамал	Олон наст	43		
6		Anabasis brevifolia C. A. Mey	Ахар навчит баглуур	1	Өвслөг ургамал	Нэг наст	10		
1	MV-012199 45°41'27.59"N, 107°40'38.10"E	Artemisia scoparia Waldst. et Kit	Ямаан шарилж	6	Өвслөг ургамал	Олон наст	30	78%	5
2		Allium polyrhizum	Таана	6	Өвслөг ургамал	Олон наст	20		
3		Reaumuria soongorica (Pall.)	Зүүнгарын улаан бударгана	2	Сөөглөг ургамал	Олон наст	8		
4		Salsola collina Pall	Толгодын бударгана	1	Өвслөг ургамал	Нэг наст	11		
5		Cleistogenes squarrosa (Trin) Keng	Дэрвээн хазаар өвс	2	Өвслөг ургамал	Олон наст	14		
1	MV-020297 45°42'11.93"N, 107°39'49.41"E	Astragalus galactites Pall.	Цагаан хунчир	2	Өвслөг ургамал	Олон наст	8	59%	6
2		Salsola	Хамхуул бударгана	1	Өвслөг ургамал	Нэг наст	36		
3		Alyssum desertorum Stapf	Цөлийн шар дэмэг	3	Өвслөг ургамал	Нэг наст	10		
4		Astragalus laguroides Pall	Туулийн хунчир	2	Өвслөг ургамал	Олон наст	8		
5		Allium polyrhizum	Таана	5	Өвслөг ургамал	Олон наст	15		
6		Stipa glareosa P. Smim	Сайрын хялгана	3	Өвслөг ургамал	Олон наст	22		
1		Stipa glareosa P. Smim	Сайрын хялгана	5	Өвслөг ургамал	Олон наст	27		

2	MV-020297 45°42'13.03"N, 107°39'49.21"E	Artemisia	Агь	3	Өвслөг ургамал	Олон наст	19	80%	5
3		Artemisia scoparia Waldst. et Kit.	Ямаан шарилж	6	Өвслөг ургамал	Олон наст	7		
4		Enneapogon desvauxii Beauv.	Умардын оготны сүүл	2	Өвслөг ургамал	Нэг наст	7		
5		Eragrostis minor Host	Бага хуралж	3	Өвслөг ургамал	Нэг наст	6		
1	Хяналтын цэг-1 45°41'27.59"N, 107°40'38.08"E	Artemisia caespitosa Ldb	Дэгнүүлт шарилж	9	Сөөглөг ургамал	Олон наст	39	73%	5
2		Stipa glareosa P.Smim	Сайрын хялгана	4	Өвслөг ургамал	Олон наст	20		
3		Salsola	Хамхуул бударгана	1	Өвслөг ургамал	Нэг наст	12		
4		Agropyron crisatum (L.) P.B.	Саман ерхөг	1	Өвслөг ургамал	Олон наст	4		
5		Allium polyrhizum	Таана	4	Өвслөг ургамал	Олон наст	18		
1	Хяналтын цэг-2 45°41'00.25"N, 107°41'49.24"E	Artemisia caespitosa Ldb	Дэгнүүлт шарилж	30	Сөөглөг ургамал	Олон наст	31	44%	3
2		Allium polyrhizum	Таана	3	Өвслөг ургамал	Олон наст	12		
3		Anabasis brevifolia C. A. Mey	Ахар навчит баглуур	1	Өвслөг ургамал	Нэг наст	6		



Зураг 21. Уурхайн орчим бичиглэл хийж буй байдал

Дүгнэлт: Тусгай зөвшөөрлийн 2 талбайд ургамлан бүрхэвчийн судалгааг хийхэд 3-6 зүйлийн ургамал таарах ба олон наст өвслөг ургамал зонхилж байна.

Ургамлын бүрхэц, төрлийг 2024 онтой харьцуулахад өөрчлөлт бага байгаа боловч бодгалийн тоогоор ус шаардахгүй, ганд тэсвэртэй шарилжны төрлийн ургамлууд түлхүү ургасан байна. Энэ нь ургамал ургах үе болох 6-7 сард хур тунадасны хэмжээ өмнөх жилээс 38,2%, олон жилийн дунджаас 20,1% бага байсантай холбоотой гэж үзэж байгаа бөгөөд цаашид хяналт мониторингийг тогтмол хийх шаардлагатай байна.

13.5 Амьтны аймгийн хяналт шинжилгээ

Уурхайн талбайгаас 10км радиуст амьтны мониторингийг хийхэд хөхтөн амьтдаас туулай, зараа, үнэг хэвлээр явагчдаас хонин гүрвэл, могой гүрвэл жигүүртэн амьтдаас тас, хэрээ элбэг үзэгдсэн. Амьтдын бүртгэлийг хийж ERP системд оруулан мэдээллийн сан үүсгэсэн.



Зураг 22. Амьтны үзэгдлийн бүртгэл


13.6 Дуу шуугианы хэмжилт

Дуу шуугианы хэмжилтийг дотооддоо сар бүр мониторингийн 4 цэгт PCE-EM883 багажаар загварын багажаар хийж гүйцэтгэсэн. Энэхүү багаж нь 30-160 дБ-ийн хоорондох дуу чимээний утгыг хэмждэг. Хэмжилтийн утгыг “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөгдөх дээд хэмжээ, ажилтны сонсгол хамгаалахад тавих ерөнхий шаардлага” MNS 6768:2019 стандарттай харьцуулав.

Хүснэгт 24. Дуу шуугианы хэмжилтийн дүн

Цэгүүдийн байршил	1-р сар	2-р сар	3-р сар	4-р сар	5-р сар	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар
Хөрсний овоолго	66.2	65.65	74.35	64.55	64.9	66.8	68.95	55.05	43.1	41.7
Уурхайн хотхон	56.65	61.5	58.25	58.5	56.65	39.1	48.85	31.35	33.2	25.25
Засвар үйлчилгээний төв	72.65	60.15	51.35	58.75	60.3	47.4	69.35	59.3	50.2	51.8
Уурхайн карьер	74.55	72.1	67.55	66.2	66.45	76.8	60.3	64.3	53.35	50.45
MNS 6768:2019	83									

График 6. Стандарттай харьцуулсан дүн



Хэмжилтийн дүнг MNS 6768:2019 стандарттай харьцуулахад ЗДХ-ээс хэтэрсэн үзүүлэлт ажиглагдахгүй байна.

13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 25. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох газраар батлуулж, биелэлтийг хангах	Уурхайн хэмжээнд	2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯ-р батлуулан, биелэлтийг ханган ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Хуваарийн дагуу хийх
2	Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах, ус ашиглалтын мэдээ тайланг боловсруулан холбогдох газруудад хүргүүлэх, төлбөрийг төлөх		2024 оны ус ашиглалтын тайланг гарган УТГХДТСГЗ, аймгийн БОАЖГ-р баталгаажуулсан. Уурхайн ус ашиглах дүгнэлтийг гаргуулж, ус ашиглах зөвшөөрлийг Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаанд хүргүүлсэн	9,780,710.0	
3	Хаягдал бохир усны дүгнэлт, хаягдал бохир ус зайлуулах зөвшөөрөл, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах, төлбөрийг төлөх		Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газрын захиргаанд Хаягдал бохир усны дүгнэлт гаргуулах албан хүсэлтийг илгээсэн	-	
4	Хог хаягдлын гэрээ байгуулж, гүйцэтгэлийг хангах		Уурхайн хог хаягдлын гэрээг хийж төлбөрийг төлсөн.	Үйл ажиллагааны зардлаас	

5	35/6 кв дэд станц Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх	Инженер геодези ХХК-тай гэрээ байгуулахаар тайлан хийлгэнэ ажиллаж байна	Үйл ажиллагааны зардлаас
6	Байгаль орчны хөндлөнгийн аудит хийлгэх	Эковишн ХХК-тай гэрээ байгуулана акт үйлдэнэ тайлан хүлээн авсана.	Үйл ажиллагааны зардлаас
7	Байгаль орчны сургалт семинарыг зохион байгуулж, ажилчдыг хамруулах	Байгаль орчны багц сургалтыг зохион байгуулсан.	Үйл ажиллагааны зардлаас
Нийт зардал			9,780,710.0

13.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох газраар батлуулж, биелэлтийг хангах

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯ-р батлуулан, биелэлтийг ханган ажилласан. /Батлагдсан БОМТ-г [ЭНД](#) дарж харна уу/

13.2 Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах, ус ашиглалтын мэдээ тайланг боловсруулан холбогдох газруудад хүргүүлэх, төлбөрийг төлөх

2024 оны ус ашиглалтын тайланг гарган УТГХДТСГЗ, аймгийн БОАЖГ-р баталгаажуулсан акт үйлдсэн. 2025 оны уурхайн ус ашиглах дүгнэлтийг Усны газраас гаргуулж, зөвшөөрөлийг Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газраас гаргуулахаар ажиллаж байна. Ус ашигласны төлбөр болох 9,780,710.0 төгрөгийг төлсөн. /Дүгнэлт, төлбөр төлсөн баримтыг [ЭНД](#) дарж харна уу/

13.3 Хог хаягдлын гэрээ байгуулж, гүйцэтгэлийг хангах

Уурхайн хог хаягдлын гэрээг Баянжаргалан сумын Засаг даргатай байгуулж 990,000 төгрөгийн төлбөрийг төлсөн. /Гэрээ, төлбөр төлсөн баримтыг [ЭНД](#) дарж харна уу/

13.4 Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийлгэх

Инженер геодези ХХК-тай гэрээ байгуулахаар тайлан хийлгэнэ ажиллаж байна./Гэрээг [ЭНД](#) дарж харна уу/

13.5 Байгалт орчны хөндлөгийн аудит хийлгэх

Эковишн ХХК-тай гэрээ байгуулана акт үйлдэнэ тайлан хүлээн авсана. /Гэрээг [ЭНД](#) дарж харна уу/

13.6 Байгаль орчны сургалт семинарыг зохион байгуулж, ажилчдыг хамруулах

Уурхайн 1 болон 2-р ээлжийн нийт ажилчдад байгаль орчны бохирдлыг бууруулах, урьчидлан сэргийлэх, мэдээллэх болон хог хаягдал, усны менежмент, хууль дүрэм журмын хэрэгжилт зэрэг сэдвүүдээр улирал тутам сургалт зохион байгуулсан. Сургалтанд давхардсан тоогоор 295 ажилтан хамрагдсан.

14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 26. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Ажлын гүйцэтгэл	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг
1	Дундговь аймгийн БОАЖГ	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх	Eis.mn цахим сайтаар 2025 оны тайланг хуулийн хугацаанд илгээсэн.	11 дүгээр сарын 01-ний дотор	Үйл ажиллагааны зардлаас
2	Баянжаргалан сум, багийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах	2025 оны 10-р сарын 25 өдөр Жилийн биелэлтийн тайланг уурхайн ойр орчим амьдарч буй айл өрхүүдэд танилцуулсан.	11 дүгээр сарын 01-ний дотор	Үйл ажиллагааны зардлаас
Нийт зардал					

14.1 Дундговь аймгийн БОАЖГ-т БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж тайланг хүргүүлэх

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Eis.mn цахим сайтад хуулийн хугацаанд илгээсэн.

14.2 Баянжаргалан сум, багийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж танилцуулах

Тайлант оны 4-р улиралд сумын багийн иргэдийн хурал товлогдоогүй тул Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг уурхайн ойр орчим амьдарч буй 3 малчин өрхөд танилцуулсан.



Зураг 23. Уурхай орчмын айл өрхүүдэд тайлан танилцуулж байгаа нь

15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд 24,270,000.0 төгрөг төлөвлөн тусгаж гүйцэтгэлээр 46,146,066 төгрөг зарцуулсан.

Хүснэгт 27. Нийт зардлын хэмжээ

№	Хийгдэх ажлын чиглэл	Хийгдсэн ажлын тодорхойлолт	Зарцуулалт, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	11,291,356.0
2	Нөхөн сэргээлт	Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг тусгай дансанд байршуулах	12,135,000.0
3	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа	Орон нутгийн саналын дагуу	10,400,000.0
4	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор	Нөлөөллийн бүсийн айлыг нүүлгэн шилжүүлэх боломж	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах	Ажил төлөвлөөгүй	-
6	Осол эрсдэлийн менежмент	Уурхайд ажиллаж буй ажилчид бэртэж, гэмтэх, гал түймэрээс сэргийлэх арга хэмжээ авах	-
7	Хог хаягдлын менежмент	Уурхайн хог цэгийг ариутгах, ангилан ялгалтыг сайжруулах	990,000.0
8	Орчны хяналт шинжилгээ	Усны хяналт шинжилгээ	363,000.0
		Агаарын чанарын хяналт шинжилгээ	356,000.0
		Хөрсний хяналт шинжилгээ	830,000.0
		Ургамлан бүрхэвч ба амьтны аймгийн судалгаа	-
9	Удирдлага зохион байгуулалт		9,780,710.0
	НИЙТ ЗАРДАЛ		46,146,066.0

16. ДҮГНЭЛТ

“Монголын алт” (МАК) ХХК нь Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн дагуу Байгаль хамгааллын дүрэм журмыг чанд сахин, стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг тогтмол гүйцэтгэдэг билээ.



Хөөтийн уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалах, орчны хяналт шинжилгээ болон удирдлага зохион байгуулалтын зэрэг нийт 45 ажил хийгдэхээр тусгагдсанаас тайлант хугацааг хүртэл 41 ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн, 91.1%-ийн биелэлттэй байна. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг Инженер геодези ХХК-тай гэрээг байгуулахаар тайлан, дүгнэлт гаргана ажиллаж байна. Байгаль орчны хөдлөнгийн аудит гэрээ байгуулана тайлан гаргана акт үйлдэж санал зөвлөмжийн ажлыг хэрэгжүүлж байна.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 24,270,000.0 төгрөг төлөвлөн тусгаж, тайлант оны X сарын байдлаар менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргахад 46,146,066.0 төгрөг зарцуулсан байна.


17. ХАВСРАЛТУУД

18. Шүүрлийн усны насосны тоолуур сольж суурилуулсан акт
19. Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг БОАЖЯ-ны тусгай дансанд байршуулсан баримт
20. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутагт хүлээлгэн өгсөн акт
21. Хог хаягдлын гэрээ, төлбөр төлсөн баримт
22. Аюултай хог хаягдлын гэрээ, хаягдал тос масло хүлээлгэн өгсөн тухай дагалдах маягт
23. Усны шинжилгээний дүн
24. Хөрсний шинжилгээний дүн
25. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн
26. Агаарын шинжилгээний дүн
27. Батлагдсан 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нүүр
28. Ус ашиглуулах дүгнэлт, төлбөр төлсөн баримт
29. Байгаль орчны аудитын гэрээ

Хавсралт 1. Шүүрлийн усны насосны тоолуур сольж суурилуулсан акт

		ХӨӨТИЙН УУРХАЙ	
2025 оны 04 сарын 22 өдөр		№26	Дундговь аймаг Баянжаргалан сум
УУРХАЙН ШҮҮРЛИЙН УСНЫ НАСОСНЫ ТООЛУУР СУУРИЛУУЛСАН АКТ			
Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөөтийн нүүрсний уурхайн шүүрлийн усны насост LXSC загварын 100м³ цагийн хэмжих хязгаартай, 150мм -ийн голчтой, 014 дугаар лацтай, 091161м³ заалттай тоолуурыг Баянжаргалан сумын байгаль орчны мэргэжилтэн Х.Сарангэрэл, уурхайн дарга Н.Гантулга, байгаль орчны инженер Д.Чулуунчимэг, уулын мастер Д.Дорждаваа, насосчин Т.Отгонбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 04 дүгээр сарын 22-ний өдөр суурилуулан акт үйлдсэн болно. Тоолуур суурилуулах үеийн фото зураг, тоолуурын баталгаажуулалтыг хавсаргав.			
ТООЛУУР ТАВЬСАН:			
Дундговь усны газар			
АКТ ҮЙЛДСЭН:			
Баянжаргалан сумын байгаль орчны мэргэжилтэн:			Х.Сарангэрэл
“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН			
Уурхайн дарга:			Н.Гантулга
Байгаль орчны инженер:			Д.Чулуунчимэг
Уулын мастер:			Д.Дорждаваа
Насосчин:			Т.Отгонбаяр



	СТАНДАРТ, ХЭМЖИЛЭГ ГАЗАР	УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ № ЭУ <u>139177</u>	
		0	д
(хэрэглэгчийн нэр)			
өшиглөж байгаа	LXSC	загварын	100.0 м ³ /ц
хэмжих хязгаартай, 150	мм-ийн голчтой №	23062258	ын
халуун, хүйтэн усны тоолуурыг №	014	лацаар битүүмжилж	
(доогуур зураг)			
2026 оны	03	р сарын	20 ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.			
Шалгалтын дараах заалт:		000014	м
Лабораторийн гэмдэг			
2024 оны		03	р сарын 20 ны өдөр
		Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг	

Хавсралт 2. Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг БОАЖЯ-ны тусгай дансанд
байршуулсан баримт



ГОЛОМТ БАНК
Сайн сайнхны салбар/бүс

Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн давлах дугаар: 318422991

Татсан огноо: 2025-02-13 09:09

Шалгуулагчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8140000114 MN860015008140000114	100900013406	12,135,000.00 MNT	Амжилттай
Шалгуулагчийн нэр МОНГОЛЫН АЛТ МАК	Хүлээн авагчийн нэр БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	Гүйлгээний утга МАК Хөөт MV-012199 талбайн байгаль орчны барьцаа 2095025 Гүйлгээний огноо 2025-02-12	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан		

Гүйлгээг хийсэн хэрэглэгч	Гүйлгээг хийсэн хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
Б. Ариунаа	Д. САЙНЖАРГАЛ	Н. ЦЭЦМҮҮН

Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

Хавсралт 3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлыг орон нутагт хүлээлгэн өгсөн
АКТ



ХӨӨТИЙН УУРХАЙ

2025 оны 9 дугаар сарын 19-ны өдөр№ 36Улаанбаатар хот

2025 ОНЫ БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН АКТ

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөөтийн нүүрсний уурхай нь 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан сумын хогийн цэгт алсын зайн хяналт хийх зориулалттай нарны эрчим хүчээр ажилладаг, өдрийн цагаар 200-300м, шөнийн цагаар 150м хүртэлх зайг харах боломжтой, 4МР өндөр нягтралтай, 360° эргэдэг, хөдөлгөөн мэдэрч хөдөлдөг, бороо усны хамгаалалттай, -30° хүйтэнд тэсвэртэй 1 ширхэг камер, анхааруулах, хориглох мэдээлэл бүхий 3 ширхэг самбарыг суурилуулан орон нутагт хүлээлгэн өгөв.




Энэхүү ажилд нийт 10,400,000 /арван сая дөрвөн зуун мянга/ төгрөг зарцуулав.

Зардлын тооцоо болон фото зургуудыг хавсаргав.

Жич: Камерын хяналтыг 3-р багийн дарга Б.Пүрэвбаярын гар утсанд суулган ажиллагаанд оруулсан.

Цаашид камер, самбарын бүрэн бүтэн байдалд Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газар хяналт тавих ба малчид иргэдийн болгоомжгүй үйлдэл, зүй бус ашиглалтаас эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засаж сайжруулах ажлыг хариуцна.

Хүлээлгэн өгсөн:

“Монголын Алт” ХХК-г төлөөлж:		
Уурхайн дарга		Н.Гантулга
Байгаль орчны инженер		Б.Гэрэлтуяа
Цахилгааны инженер		Б.Сүхбаатар

Хүлээн авсан:

Дундговь аймгийн Баянжаргалан сумыг төлөөлж:		
Засаг дарга		О.Ууганбаатар
3-р багийн дарга		Б.Пүрэвбаяр
Байгаль орчны мэргэжилтэн		Х.Сарангэрэл



БҮТЭЭГЧ МОНГОЛЫН ТӨЛӨӨ
www.mak.mn | Монголын Алт МАК | MongolianAltMAK



Зураг 1. Камер угсралтын ажил хийгдэж байгаа нь



Зураг 2. Самбар суурилуулж, камерын хяналтын холболт хийж байгаа нь

ХӨӨТИЙН УУРХАЙН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ГАРСАН ЗАРДЛЫН ТООЦОО

Хөөтийн уурхайн 2025 оны биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан сумын хогийн цэгт хяналтын камер, тэмдэг тэмдэглэгээ суурилуулах саналыг ирүүлсний дагуу хийж, гүйцэтгэсэн. Тус ажилтай холбоотойгоор гарсан зардлыг дараах байдлаар тооцлоо.

НЭГ. Ажлын зардлын тооцоо

№	Үзүүлэлт	Хэм.нэгж	Дүн
1	Ажилласан техник	төг	244,400
	1.1 Land Cruiser-79 (a*b)	төг	244,400
	a. Үнэлгээ (Түлш, Оператор бусад зардал орсон)	төг/км	4,700
	b. Туулсан зай	км	52
2	Цалингийн зардал (2.1*(2.2+2.3+2.4+2.5))	төг	1,304,600
	2.1 Ажилласан цаг	цаг	11
	2.2 Цахилгааны инженер	төг/цаг	30,600
	2.3 Байгаль орчны инженер	төг/цаг	30,600
	2.4 Дэд станцын диспетчер	төг/цаг	28,000
	2.5 Эскаваторын оператор	төг/цаг	29,400
3	Материалын зардал (3.1+3.2+3.3+3.4)	төг	8,836,657
	3.1 Хаяг самбар (a*b)	төг	2,700,000
	a. Нэгжийн өртөг	төг/шир	900,000
	b. Тоо хэмжээ	шир	3
	3.2 Хяналтын камер (a*b)	төг	5,999,900
	a. Нэгжийн өртөг	төг/шир	5,999,900
	b. Тоо хэмжээ	шир	1
	3.3 Цементийн шуудай (a*b)	төг	666
	a. Нэгжийн өртөг	төг/шир	666
	b. Тоо хэмжээ	шир	1
	3.4 Төмөр шон (a*b)	төг	136,091
	a. Нэгжийн өртөг	төг/шир	27,218
	b. Тоо хэмжээ	шир	5
4	Нийт (1+2+3)	төгрөг	10,385,657

Хогийн цэг тохижуулах ажлын явцад техникийн зардалд **244 мян.төгрөг**, цалингийн зардалд **1.3 сая.төгрөг**, материалын зардалд **8.8 сая.төгрөг**ийн зардал тус тус гарсан. Нийт зардал **10.4 сая.төгрөг** байна.

ТООЦСОН:

Эдийн засагч:

Г. Жавхлан

Г. Жавхлан

2025.09.16

Хавсралт 4. Хог хаягдлын гэрээ, төлбөр төлсөн баримт

БАТЛАВ. МОНГОЛЫН АЛТ (МАК) ХХК-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЦЭЛМҮҮН  2025 оны 02 сарын 11 өдөр	БАТЛАВ. ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГА О.УУГАНБААТАР  Дундговь аймаг
ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ № 85-1925	

Нэг талаас: Дундговь аймаг, Баянжаргалан сум, 3-р баг, Аргатай, сумын төв хаягт байрлах 9033602 тоот регистрийн дугаартай Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг Даргын тамгын газар /цаашид “ЗДТГ” гэх/, түүнийг төлөөлж Байгаль орчны мэргэжилтэн Хүрэлхүү овогтой Сарангэрэл,

Нөгөө талаас: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, 19-р хороолол, Чингисийн өргөн чөлөө, Төв байр-44 хаягт байрлах 2095025 регистрийн дугаартай “Монголын Алт” (МАК) ХХК /цаашид “Аж ахуйн нэгж байгууллага” гэх/ түүнийг төлөөлж Дундговь аймаг, Баянжаргалан сумын 2-р баг, Хөөтийн уурхайн дарга Нямсүрэн овогтой Гантулга нар харилцан тохиролцож Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Баянжаргалан сумын ИТХ-ийн 2019 оны 05 тоот тогтоолыг тус тус үндэслэн энэхүү гэрээг /цаашид “Гэрээ” гэх/-г дараах нөхцөлөөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр сумын ЗДТГ нь Дундговь аймаг, Баянжаргалан суманд байрлах “Монголын Алт” МАК ХХК-ийн Хөөтийн уурхайн цуглуулж, тээвэрлэж ирсэн хог хаягдлыг булаах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж байгууллага гэрээнд заасан төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх эрх зүйн харилцааг зохицуулахад энэхүү Гэрээний зорилго оршино.
- 1.2. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба 2025 оны 02 сарын 11-ний өдрөөс 2026 оны 02 сарын 11-ийг хүртэлх хугацаанд хүчинтэй байна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 2.1. Хөөтийн уурхайн хог хаягдлын үйлчилгээний төлбөр нь 1 /нэг/ сарын 80,000 /наян мянга/ төгрөг, 1 /нэг/ жилийн 960,000 /есөн зуун жаран мянга/ төгрөг, эмнэлгийн хог хаягдалд 1 /нэг/ ажилтан х 2500х12=30,000 /гучин мянга/ төгрөг байх бөгөөд нийт төлбөр 990,000 /есөн зуун ерэн мянга/ төгрөг байна.
- 2.2. Аж ахуйн нэгж байгууллага нь гэрээний 2.1-т заасан хог хаягдлын төлбөрийг Төрийн сан банкны 100080500947 тоот дансанд тушаана.

ГУРАВ. СУМЫН ЗДТГ-ЫН ЭРХ

- 3.1. Сумын ЗДТГ дараах эрхтэй. Үүнд:
 - 3.1.1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах;
 - 3.1.2. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх;
 - 3.1.3. Иргэд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих;
 - 3.1.4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэд хяналт тавих.

ДӨРӨВ. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Аж ахуйн нэгж байгууллага дараах үүрэгтэй. Үүнд:
 - 4.1.1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх;

- 4.1.2. ААН, байгууллага нь хог хаягдал гаргасан төлбөрөө улирал бүрийн сүүл сарын 15-ны дотор гэрээнд зааснаар Дундговь аймгийн Баянжаргалан сумын татварын байцаагчтай холбогдож хог хаягдлын төлбөрөө төлөх;
- 4.1.3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх;
- 4.1.4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаарх дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах;
- 4.1.5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх;
- 4.1.6. Хог хаягдлыг ангилан хаях талаар мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлэх, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах;
- 4.1.7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох;
- 4.1.8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас шаардах;
- 4.1.9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх;
- 4.1.10. Дундговь аймгийн Баянжаргалан сумын татварын байцаагчтай холбогдож хог хаягдлын төлбөрөө төлөх;
- 4.1.11. Хог хаягдлын цэгийг сард нэг удаа түрэх, шуух;
- 4.1.12. Камер гэрэлтүүлгийг хийх;
- 4.1.13. Эмнэлгийн хог хаягдлыг зориулалтын дагуу устгал хийх;
- 4.1.14. Тухайн уурхай туслан гүйцэтгэгч ААН-ээр ажил гүйцэтгүүлсэн тохиолдолд орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах /ажиллах хугацааны/.

ТАВ. БУСАД НӨХЦӨЛ

- 5.1. Хог хаягдал гаргасны төлбөрийн хэмжээ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.
- 5.2. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хоёр тал харилцан тохиролцож нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэнэ.
- 5.3. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарсан маргаантай асуудлыг талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол Монгол улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 5.4. Талууд энэхүү гэрээг 3 хувь үйлдэж аж ахуйн нэгж байгууллага 2 хувь, сумын ЗДТГ 1 хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хуулийн адил хүчинтэй байна.


ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 6.1. Аж Ахуй нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохирлыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно. Аж Ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“Монголын Алт” (МАК) ХХК-г төлөөлж

Хөөтийн уурхайн дарга Н.Гантулга



Утас: 96964565

Дундговь аймаг, Баянжаргалан сумын ЗДТГ-г

төлөөлж Байгаль орчны мэргэжилтэн Х.Сарангэрэл



Утас: 88032429






Цахим гүйлгээний баримт

Хүсэлтийн лавлах дугаар: 366455475

Татсан огноо: 2025-09-23 10:55

Шилжүүлэгчийн дансны дугаар	Хүлээн авагчийн данс	Гүйлгээний дүн	Гүйлгээний төлөв
8140000114 MN860015008140000114	MN190090100080500947 MN190090100080500947	990,000.00 MNT	Амжилттай
Шилжүүлэгчийн нэр МОНГОЛЫН АЛТ МАК	Хүлээн авагчийн нэр ДУ.БА ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖ	Гүйлгээний утга МАК-Хөөтийн уурхайн 2025 оны Хог хаягдлын төлбөр 2095025	
	Хүлээн авагчийн банк Төрийн сан	Гүйлгээний огноо 2025-09-22	

Гүйлгээг шивсэн хэрэглэгч	Гүйлгээг хянасан хэрэглэгч	Гүйлгээг баталсан хэрэглэгч
Б. Ариунаа	А. БИЛЭГСЭЙХАН	Н. ЦЭЦМҮҮН



Бүх эрх хуулиар хамгаалагдсан ©. Голомтбанк ХК.

БАТЛАВ: “МОНГОЛЫН АЛТ” ХХК
-ийн Ерөнхийлөгч Н.ЦЭЛМҮҮН



БАТЛАВ: “ТӨВШИН САЙХАН МӨНХ” НҮТББ-
ийн УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
С.ЦЭРЭНЖАВ



655-1123 ТООТ ГЭРЭЭНД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2025 оны 05-р сарын 01-ний өдөр

№

010-1125

Улаанбаатар хот

Нэг талаас: “Төвшин сайхан мөнх” НҮТББ (цаашид “А тал” гэх), түүнийг төлөөлж
Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн,

Нөгөө талаас: “Монголын Алт” (МАК) ХХК (цаашид “Б тал” гэх), түүнийг төлөөлж
Хангамж, техник үйлчилгээний газрын захирал Д.Нинжбадгар, бид нар (цаашид хамтад нь “Талууд”
гэх) Монгол Улсын Иргэний хууль болон Талуудын хооронд байгуулагдсан 2023 оны 07 сарын 20-ны
өдрийн 655-1123 тоот “Хог хаягдал нийлүүлэх гэрээ” (цаашид “Үндсэн гэрээ” гэх)-ний 7.2 дахь
заалтыг тус тус үндэслэн энэхүү “655-1123 тоот гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээ”
(цаашид “Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ” гэх)-г дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Үндсэн Гэрээнд заасан гэрээний хугацааг сунгахаар Талууд харилцан тохиролцсон ба Үндсэн
гэрээнд нэмэлт, өөрчлөлтийг оруулахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү Нэмэлт,
өөрчлөлт оруулах гэрээний зорилго оршино.
- 1.2. Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээгээр зохицуулаагүй харилцааг Үндсэн гэрээгээр
зохицуулна.
- 1.3. Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ нь Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж,
тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

ХОЁР.ҮНДСЭН ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

2.1 Үндсэн гэрээнд дараах өөрчлөлтийг оруулав. Үүнд:

- 2.1.1. Үндсэн гэрээний 2.4-т заасан гэрээний хугацааг энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ
хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 12 сарын хугацаагаар сунгав.
- 2.1.2. Үндсэн гэрээний 2.3-т “Нийлүүлэгч болон түүний охин, хараат компани мөн түүний
хамаарал бүхий компани гэдэгт дараах компаниудыг ойлгоно” гэсэн заалтыг “Нийлүүлэгч
болон түүний охин, хараат компани, салбар, нэгж мөн түүний хамаарал бүхий компани,
салбар, нэгж гэдэгт дараах компаниудыг ойлгоно. Үүнд:

	Компани, нэгж	Регистрийн дугаар
1	“Монголын Алт (МАК)” ХХК	2095025
2	“МАК Цемент” ХХК	5830974
3	“Хүрэн толгой Коал Майнинг” ХХК	2697947
4	“Шивээ Хүрэн Терминал” ХХК	3649245
5	“Трү ти ар си” ХХК	6610188
6	“Эрдэнэс цагаан суварга” ХХК	5824826
7	“МАК Аранжин Зэс” ХХК	5849187
8	МАК Централ	2554798
9	“Аян хотелс энд ресорте” ХХК	6886647
10	“Хүннү Эйр” ХХК	5514339
11	Засвар Үйлчилгээний төв	-
12	МАК Ийст	-
13	МАК Вест	-

гэж өөрчлөв.

2.2. Үндсэн гэрээнд дараах нэмэлтийг оруулав. Үүнд:

- 2.2.1. Үндсэн гэрээний 1.3-т “Хавсралт 2 - Хүлээлгэж өгөх дахивар нөөц; Хавсралт 3 – Хүлээлгэж өгөх дахивар нөөцийн төлөвлөгөөт хэмжээ” гэж нэмэлт оруулав.
- 2.2.2. Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний Хавсралт №1-т заасныг Үндсэн гэрээний Хавсралт №2 болгон нэмэлт оруулав.
- 2.2.3. Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний Хавсралт №2-т заасныг Үндсэн гэрээний Хавсралт №3 болгон нэмэлт оруулав.
- 2.2.4. Үндсэн гэрээний 4.1 дүгээр зүйлд “4.1.11. А тал нь Б талаас гарах дахиврыг зориулалтын дахиврын үйлдвэрт түүхий эд бэлтгэх зорилгоор хүлээж авна. А тал нь Б талаас гарах дахиврыг түүхий эд бэлтгэхээс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно. Өөр зориулалтаар ашигласан тохиолдолд гарах үр дагаврыг А тал бүрэн хариуцна” гэсэн заалтыг нэмэв.
- 2.2.5. Үндсэн гэрээний 4.1 дүгээр зүйлд “4.1.12. Б тал нь Үндсэн гэрээний Хавсралт №3-т заасан төлөвлөгөөт дахивар нөөцийг бүрэн нийлүүлж чадаагүй тохиолдолд, нийлүүлэгдээгүй болон дутуу нийлүүлсэн хэмжээг тодорхойлон гаргах бөгөөд уг зөрүүг дараагийн улирлуудад нөхөн нийлүүлэх, идэвхжүүлэх арга хэмжээ авахыг эрмэлзэнэ.” гэсэн заалт нэмэв.


ГУРАВ. БУСАД НӨХЦӨЛ

- 3.1 Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ нь хүчин төгөлдөр болсноор Талуудын хооронд байгуулсан Үндсэн гэрээнд энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээний 2 дугаар зүйлд заасан нэмэлт, өөрчлөлт орсонд тооцно.
- 3.2 Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ нь Талуудын хооронд байгуулагдсан 2023 оны 07 сарын 20-ны өдрийн 655-1123 тоот Үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.
- 3.3 Энэхүү Нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээг 3 хувь үйлдэж Б тал 2 хувь, А тал 1 хувийг тус тус хадгалах бөгөөд Өөрчлөлт оруулах гэрээний хувиуд хуулийн адил хүчинтэй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


А талыг төлөөлж:

Гүйцэтгэх захирал О.Лхагвасүрэн



Б талыг төлөөлж:

ХТҮГ-ын Захирал Д.Нинжбадгар



Хавсралт 5. Аюултай хог хаягдлын гэрээ, хүлээлгэн өгсөн аюултай хог хаягдлын дагалдах маягт

БАТЛАВ: “МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН
ЕРӨНХИЙЛӨГЧ НЦЭЛМҮҮН



ХАЯГДАЛ ТОС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 05 сарын 20-ны өдөр

№

640-1125

Улаанбаатар хот

Нэг талаас: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 14-р хороо, 19 хороолол, Чингисийн өргөн чөлөө, Төв байр-44 хаягт байрлах 2095025 тоот регистрийн дугаартай “Монголын Алт” (МАК) ХХК /цаашид “Нийлүүлэгч” гэх/, түүнийг төлөөлж Ажил үйлчилгээ, худалдан авалтын газрын захирал Д.Нинжбадгар,

Нөгөө талаас: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, энканто таун, 306, 22 тоот хаягт байрлах 6987427 тоот регистрийн дугаартай “ОБ ойл индустриал” ХХК /цаашид “Хүлээн авагч” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Одсүрэн бид нар /хамтад нь “Талууд” гэх/, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам” болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Нийлүүлэгч болон түүний охин, хараат мөн хамаарал бүхий компаниудаас гарах хаягдал тосыг аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу цуглуулан хүлээн авагчид нийлүүлэх, хүлээн авагч нь хаягдал тосыг зөөж ачих, тээвэрлэх устгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ байгаль орчны бохирдол гаргахгүй, галын аюулгүй байдлыг бүрэн сахиж, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд үйл ажиллагаа явуулна.
- 1.3. Хүлээн авагч нь энэхүү гэрээг хэрэгжүүлэхээс өмнө дор дурдсан баримт бичгүүдийг Нийлүүлэгч талд гаргаж өгнө. Үүнд:
 - 1.3.1. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл;
 - 1.3.2. Эрсдлийн үнэлгээ;
 - 1.3.3. Ажиллагсадын Химийн хорт болон аюултай бодистой харьцах сургалтад суусан бүртгэл, мэдээлэл;
 - 1.3.4. Үндсэн ажлын процесс зураглал.
- 1.4. Энэхүү гэрээний талууд нөгөө талынхаа хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, нууцыг чанд хадгалах зарчмыг баримтлан ажиллана.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ, ХУГАЦАА

- 2.1. Хүлээн авагч нь Нийлүүлэгч болон түүний охин, хараат мөн хамаарал бүхий компаниудаас ашигласан тос, тосол, гидрийн шингэн /цаашид хамтад нь “Хаягдал тос” гэх/-ийг аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу цуглуулан актаар хүлээн авч зөөж ачиж, тээвэрлэн, дахин боловсруулах буюу устгана.
- 2.2. Нийлүүлэгч болон түүний охин, хараат мөн түүний хамаарал бүхий компани гэдэгт дараах компаниудыг ойлгоно. Үүнд:

№	Компани	Регистрийн дугаар
1	“Монголын Алт” (МАК) ХХК	2095025

2	“МАК Цемент” ХХК	5830974
3	“Эрдэнэс цагаан суварга” ХХК	5824826
4	“МАК Аранжин зэс” ХХК	5849187
5	“Тру ти ар си” ХХК	6610188
6	“Хүрэн толгой коал майнинг” ХХК	2697947

- 2.3. Энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш **1 жилийн хугацаанд** хүчинтэй байна.
- 2.4. Талууд гэрээг цуцлах саналаа ажлын 10 хоногоос доошгүй хугацаанд нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 2.5. Аль нэг талаас гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн буюу удаа дараа хангалтгүй биелүүлсэн тохиолдолд гэрээг нэг талын санаачилгаар цуцалж болно.

ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТӨЛБӨР

- 3.1. Нийлүүлэгчийн нийлүүлэх Хаягдал тосны үнэ нь **1 литр тутамд 50 /тавь/ төгрөг** байна.
- 3.2. Хаягдал тос тээвэрлэлтийн зардал нь гэрээний 3.1-т заасан үнэд багтаагүй бөгөөд Хаягдал тосыг эх үүсвэрээс цуглуулах, тээвэрлэхтэй холбогдох бүхий л зардлыг Хүлээн авагч өөрөө хариуцна.
- 3.3. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд ачилтын тоо хэмжээ, хугацааг Талууд тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэх ба гэрээний 4.1-т заасан акт нь төлбөр төлөх үндэслэл болно.
- 3.4. Хаягдал тосны шинжилгээний лабораторийн дүнг үндэслэн ус, механик хольцын үлдэгдлийн хэмжээг хаягдал тосноос хасаж хаягдал тос хүлээн авсан бүртгэлд хөтөлнө.
- 3.5. Хаягдал тос тээвэрлэлтийн нэг удаагийн ачилт нь 40 тонн байна.
- 3.6. Хүлээн авагч нь гэрээний 3.1-т заасан үнийг гэрээний 4.1-т заасан акт үйлдсэнээс хойш Нийлүүлэгчийн нэхэмжлэхийн дагуу ажлын 5 хоногт багтаан түүний дансанд төлнө.

ДӨРӨВ. ХАЯГДАЛ ТОС ХҮЛЭЭЛЦЭХ, ТЭЭВЭРЛЭХ

- 4.1. Энэ гэрээний дагуу хаягдал тос нийлүүлэхдээ Талууд агуулах савны битүүмжлэлийг шалгаж, ачилт бүрэн дууссаныг баталгаажуулж акт үйлдэнэ. Актдад талуудын төлөөлөгчид гарын үсэг зурж 2 хувь үйлдэнэ.
- 4.2. Нийлүүлэгч нь хаягдал тос нийлүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид oboilmongolia@gmail.com и-мэйл хаягаар хүргүүлж, холбоо барих утас /99116845/-аар ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч болон тээвэрлэгчтэй харилцан тохиролцож хаягдал тос нийлүүлэх хугацааг товлон.
- 4.3. Хүлээн авагч нь Нийлүүлэгчээс товлосон өдөр, цагт аюултай хаягдал тосыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хүлээн авна. Ачилтын явцад холбогдох хууль тогтоомж, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг дагаж мөрдөнө.
- 4.4. Нийлүүлэгч нь хаягдал тосыг нийлүүлэхдээ аюултай хог хаягдлын хэмжээ, тоо ширхгийг гэрээнд заасан үнээр тооцож аюултай хог хаягдлыг шилжүүлнэ.
- 4.5. Хэрэв хаягдал тос тээвэрлэх сав нь бүтээгдэхүүний шинж чанарт тохироогүй, стандартын шаардлага хангаагүй болох нь тогтоогдвол Нийлүүлэгч хүлээлгэн өгөхөөс татгалзана.
- 4.6. Талууд энэ гэрээний 4.1-т заасны дагуу шалгаж акт үйлдсэнээр хаягдал тостой холбоотой бүх эрсдэл Хүлээн авагчид шилжинэ. Хүлээн авагч нь ийнхүү хүлээн авснаас хойших үүсэх аливаа эрсдэлийг /тээвэрлэлт хийх үе, дахин боловсруулах үед г.м/ бүрэн хариуцна.
- 4.7. Хүлээн авагч нь гэрээний дагуу нийлүүлсэн хог хаягдлыг хүний эрүүл мэнд, мал, амьтан ургамал, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх, замын хөдөлгөөнд аюултай байдал бий болгохгүй нөхцөлөөр тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр тусгайлан тоногдсон тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.
- 4.8. Хүлээн авагч нь нийлүүлсэн хог хаягдлыг зөвхөн дангаар нь тээвэрлэнэ. Тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл нь тусгай анхааруулах тэмдэгтэй байна.
- 4.9. Хүлээн авагч хаягдал тосны тээвэрлэлтийг гуравдагч этгээдээр хариуцуулан гүйцэтгүүлэх тохиолдолд энэхүү гэрээний бүх зүйл заалт нэгэн адил хүчин төгөлдөр мөрдөгдөнө.



ТАВ. НИЙЛҮҮЛЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Нийлүүлэгч нь дараах үүрэгтэй. Үүнд:

- 5.1.1 Хаягдал тосыг хүлээлгэн өгөхдөө гэрээний 4 дүгээр зүйлд заасны дагуу акт үйлдэн баталгаажуулж, Хүлээн авагчийн төлөөлөгчөөр гарын үсэг зуруулж авах;
- 5.1.2 Хаягдал тосны хуримтлалын сав нь газрын тосны бүтээгдэхүүний стандартад нийцсэн, битүүмж алдагдаагүй байх;
- 5.1.3 Нийлүүлэгчийн хаягдал тос нь хүлээн авагчийн чанар стандартыг хангахааргүй бохирдолтой /ус болон антифриз бусад шингэн үл шингэх хаягдал/ бол бохирдлыг хорогдуулан тооцох буюу Нийлүүлэгч тал хаягдал тосыг цэвэр, ямар нэгэн ус болон антифризийн шингэн хольцгүй байдлаар нийлүүлэх үүргээ чанд мөрдөнө.
- 5.1.4 Нийлүүлэгч нь Хууль болон гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэх;
- 5.1.5 Нийлүүлэгч нь урьдчилан бэлтгэх, заавар зааварчилгаа өгөх, хяналт тавих, машин орох талбайг бэлтгэх үүрэгтэй бөгөөд таталт хийж буй машиныг шалтгаангүйгээр хонуулах, ачилтын үйл ажиллагааг удаашруулах, ачилт хийгдэж байх үед хяналтгүй удаан хугацаагаар орхих үйлдлийг гаргахгүй болно.

5.2 Нийлүүлэгч нь дараах эрхтэй. Үүнд:

- 5.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
- 5.2.2 Хүлээн авагчид санал хүсэлтээ мэдэгдэж шийдвэрлүүлэх;
- 5.2.3 Хууль болон гэрээнд заасан бусад эрх;

ЗУРГАА. ХҮЛЭЭН АВАГЧ ТАЛЫН ҮҮРЭГ, ЭРХ

6.1 Хүлээн авагч нь дараах үүрэгтэй. Үүнд:

- 6.1.1 Хүлээн авагч нь эрх бүхий байгууллагаас баталсан аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх аюулгүй болгох, хадгалах устгах журмыг дагаж мөрдөх;
- 6.1.2 Хүлээн авагч нь хаягдал тосыг хүлээн авснаар тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаатай холбогдон гарсан аливаа хариуцлагыг хүлээх;
- 6.1.3 Хүлээн авагч нь хаягдал тосыг гэрээний 4 дүгээр зүйлд заасны дагуу хүлээн авч өөрийн дахин боловсруулах үйлдвэр хүртэл тээвэрлэх, дахин боловсруулалт хийх ажлыг бүрэн хариуцах;
- 6.1.4 Хүлээн авагч нь гэрээний дагуу хүлээн авсан аюултай хог хаягдлыг устгах тохиолдолд тусгайлан бэлтгэсэн талбай, зориулалтын тоног төхөөрөмж, эсхүл байгууламж бүхий зөвшөөрөгдсөн цэгт аюулгүй болгон устгах;
- 6.1.5 Хаягдал тосыг тээвэрлэх, дахин боловсруулахдаа хүрээлэн буй байгаль орчныг бохирдуулахгүй байх талаар шаардлагатай арга хэмжээг авч ажиллах;
- 6.1.6 Нийлүүлэгчийн үйлдвэр уурхайн талбайд байгаль орчин, ХАБЭА-н шаардлагуудыг биелүүлэх;
- 6.1.7 Хаягдал тосыг тээвэрлэх буюу ачилтаар хүлээн авахдаа химийн хорт болон аюултай бодистой харьцах ажиллагсадаа аюулгүй ажиллагаа, болзошгүй осол, эрсдлээс сэргийлэх болон анхны тусламж үзүүлэх сургалтад өөрийн зардлаар хамруулсан байна.
- 6.1.8 Хаягдал тос тээвэрлэх тухай бүрдээ нийлүүлэгчид заавар зөвлөмж өгөх.
- 6.1.9 Хаягдал тосыг Нийлүүлэгчийн мэдэгдсэн хугацаанд ирж хүлээн авах, Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хоногийн хоцролт гарах үед тухай бүр урьдчилан мэдэгдэх;
- 6.1.10 Хүлээн авагч нь Нийлүүлэгчийн хэвийн үйл ажиллагаанд аль болох саад учруулахгүй байх нөхцөлийг сонгож ажиллах бөгөөд Нийлүүлэгчийн үйлдвэр уурхай, тусгай бүсэд хориглосон газар тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хэрэглэсэн байдалтай нэвтрэх, эмх замбараагүй байдал үүсгэхийг ажилтнууддаа хориглох, тийм байдал үүсэхээс сэргийлж ажиллах;
- 6.1.11 Хүлээн авагч нь Нийлүүлэгч, түүний ажилтан, харилцагчийн эд хөрөнгөнд эвдрэл, гэмтэл,

хохирол учруулахаас сэргийлэх, хохирол учруулсан нь баримтаар тогтоогдвол нөхөн төлөх;

6.1.12 Хүлээн авагч нь таталт хийх машины очих өдөр, мэдээллийг урьдчилан 2-3 хоногийн өмнө мэдэгдэх;

6.1.13 ХАБЭА-н үйл ажиллагаатай холбоотой осол, зөрчлийг Хүлээн авагч нь бүрэн хариуцах буюу Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм"-ийн дагуу орон тооны бус байнгын комиссыг байгуулсан байна.

6.1.14 Хүлээн авагчийн тээврийн хэрэгслийн жолооч, зорчигч нь дор заасан нэг бүрийн хамгаалах хэрэгсэлтэй нийлүүлэгчийн бүсэд нэвтрэх ба харуул хамгаалалтын алба хаагчид шалгуулж, тэмдэглүүлсэн байна. НБХХ-н жагсаалтад:

- Толгой хамгаалах хэрэгсэл /каска/;
- Амьсгал хамгаалах хэрэгсэл, /зориулалтын хошуувч/
- Гэрэл ойлгогч бүхий цацруулагчтай хантааз;
- Өндрийн бүс;
- Тусгай зориулалтын гутал;
- Ажлын бээлий;
- Нүд хамгаалах хэрэгсэл бүхий зориулалтын нүдний шил зэрэг хэрэгслүүдийг тээвэрлэгч талаас хариуцах бөгөөд жолооч, зорчигчид хуваариалан олгосон байна.

6.1.15. Хүлээн авагч нь нийлүүлэгчийн үйлдвэрлэлийн бүсийн замын хөдөлгөөний тухай дотоод дүрэм болон нийлүүлэгч нэгжийн ХАБЭА-н тухай бүхий л заавар, зааварчилгыг дагаж, зохих шаардлагыг биелүүлнэ.

6.2. **Хүлээн авагч нь дараах эрхтэй. Үүнд:**

6.2.1 Санал хүсэлтээ Нийлүүлэгчид мэдэгдэж шийдвэрлүүлэх;

6.2.2 Нийлүүлэгчээс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

6.2.3 Нийлүүлэгчийн Лабораторийн дүгнэлтийг үндэслэн механик хольц, усны хорогдлыг тооцон актад тусгана.

6.2.4 Хууль болон гэрээнд заасан бусад эрх.

ДОЛОО. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

7.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих журмын дагуу гүйцэтгээгүйгээс нөгөө талдаа хохирол учруулсан бол учирсан бодит хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй. Бодит хохирол гэдэгт хохирогч талд учирсан шууд хохирол болон түүний гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн хариуцлагыг ойлгоно.

7.2. Хүлээн авагч нь аюултай хог хаягдал ачих, тээвэрлэх үйл ажиллагаанд Хог хаягдлын тухай болон Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд заасан шаардлага, журам болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд холбогдох шаардлага, стандартыг хангах асуудлыг өөрөө бүрэн хариуцах буюу хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу түүнийг зөрчсөн, Үйлдвэрлэлийн осол, зөрчилд холбогдсоноос үүдэх аливаа асуудлыг Нийлүүлэгчээс ангид байлгана.

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт гэрээний талуудын хүсэл зоригоос гадуур гэрээний үүргийн гүйцэтгэлд саад болох хүчин зүйлийг ойлгоно. Энэхүү хүчин зүйл гэдэгт иргэний бослого, үймээн, зэвсэгт мөргөлдөөн, хорио цээр, үйлдвэрлэлийн талаарх засгийн газраас хэрэгжүүлэх арга хэмжээ болон байгалийн давагдашгүй хүчин зүйлс болох салхи шуурга, гал түймэр, газар хөдлөлт, үер зэрэг гамшигт нөхцөл байдал хамаарна. Энэхүү гэнэтийн болон давагдашгүй хүчний нөлөөллөөс болж талууд үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд тус хугацаагаар гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх хугацаа сунгагдах ба энэ тохиолдолд аль ч тал хариуцлага хүлээхгүй. Ийнхүү гэнэтийн болон давагдашгүй хүчний нөлөөлөл болсон гэдгийг талууд баримтаар баталгаажуулах үүрэгтэй.

- 8.2. Хэрэв Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс зохих ёсоор гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдалд орсон бол нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

ЕС. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1. Энэхүү Гэрээг хэрэгжүүлэх явцад гэрээний үүргийн гүйцэтгэл болон хуулийн дагуу үүсэж болох бүхий л үүргийн гүйцэтгэлтэй холбоотой аливаа маргааныг гэрээний талууд нэн тэргүүнд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 9.2. Талууд харилцан тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд Монгол улсын шүүхээр хянан шийдвэрлүүлнэ.
- 9.3. Энэ гэрээ нь Монгол Улсын хуулийн дагуу үйлдэгдсэн ба тэдгээр хуулийн хэм хэмжээнд тайлбарлагдан ойлгогдоно.


АРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 10.1. Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
- 10.2. Энэхүү гэрээ хэрэгжих явцад гэрээнд аливаа нэмэлт өөрчлөлт оруулах, нэмэлт гэрээ байгуулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 10.3. Энэхүү Гэрээг Монгол хэл дээр бичгээр 2 хувь үйлдэх Талууд тус бүртээ 1 хувийг хадгална.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Нийлүүлэгчийг төлөөлж:

АУХАГ-ын захирал Д.Нинжбадгар



Гэрээ хариуцсан хуульч Б.Билгүүн



Хүлээн авагчийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал Г.Одсүрэн



2024- тоот гэрээний
Хавсралт № 1

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№ 01/2025

Дагалдах бичгийн дугаар: 2025/01

/шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ./

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл: Бүртгэлийн дугаар: Y-001656. Нэр:								
2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн: Овог нэр: Б. Гэрэлтуяа Албан тушаалтан: БОМэргэжилтэн Гарын үсэг: Огноо: 2025 он 09 сар 17 өдөр								
3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл: 1/ Тээврийн хэрэгсэлийн улсын дугаар: 44-30.9ET. Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр: ОБ ОЙЛ ИИДАСТРИАЛ ХХК. Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар: ИИДАСТРИАЛ ХХК.								
4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:								
	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилал	Савлагааны бүлэг	Савны дугаар		Хэмжээ	Нэгж/кг Эсвэл/ш	Аюултай хог хаягдлын код
1.	ДЭМЖИЭСОН ТХ					6400д		
2.								
5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:								
6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :								
1. Овог нэр: Ганзориг Гарын үсэг: 2025 он 09 сар 17 өдөр								
7. Үл зохицол:								
